




МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХҮН АМ, ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

# ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА



2025 он



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХҮН АМ, ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

# ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА 2025 ОН

УЛААНБААТАР ХОТ

Судалгааг гүйцэтгэсэн: Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн

Хөдөлмөрийн судалгааны сектор

М.Батгэрэл ХАХНХССХ-ийн захирал

Н.Жаргалсайхан ХСС-ын эрхлэгч

У. Мөнхзаяа ХСС-ын эрдэм шинжилгээний ажилтан

Э.Түвшинзаяа ХСС-ын эрдэм шинжилгээний ажилтан

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Б.Хос-Эрдэнэ ИӨМТГ-ын өгөгдлийн инженер

Хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
Нарны зам, 55-р байр, 2-р давхар

Утас: 77111331, 77121286

Веб хуудас:

<https://institute.gov.mn/>

<https://www.gov.mn/org/triplsp>

## АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ .....	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	6
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	7
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .....	10
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ .....	11
<b>БҮЛЭГ 1. УДИРТГАЛ .....</b>	<b>15</b>
1.1 Судалгааны үндэслэл .....	16
1.2 Судалгааны зорилго .....	16
1.3 Судалгааны түүврийн эх олонлог, хүрээ .....	17
1.4 Судалгааны зохион байгуулалт .....	17
1.4.1 Асуулгын хуудасны бүтэц .....	17
1.4.2 Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт .....	17
1.5 Ойлголт, тодорхойлолт .....	18
<b>БҮЛЭГ 2. ТӨГСӨГЧДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....</b>	<b>25</b>
2.1 Төгсөгчдийн хүн ам зүйн төлөв байдал .....	26
2.2 Төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийн чиглэл .....	27
2.3 Төгсөгчдийн сургууль болон мэргэжлийн талаарх үнэлэмж .....	30
<b>БҮЛЭГ 3. ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ .....</b>	<b>33</b>
3.1 Хөдөлмөр эрхлэлтийн шинж байдал .....	35
3.2 Мэргэжил, боловсрол, ур чадварын нийцэл .....	45
3.3 Ажлын байранд тулгарч буй асуудал, бэрхшээл .....	54
<b>БҮЛЭГ 4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ОРЛОГО .....</b>	<b>55</b>
4.1 Хөдөлмөрийн орлого .....	56
4.2 Орлогын ялгаатай байдал .....	59
<b>БҮЛЭГ 5. АЖИЛ ХАЙХ ЯВЦ .....</b>	<b>61</b>
5.1 Ажил хайж буй хэлбэр, тулгамдаж буй асуудал .....	62
5.2 Ажлын цаг, давхар хөдөлмөр эрхлэх байдал .....	67

БҮЛЭГ 6. ӨМНӨХ ҮЕИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ .....	71
6.1 Суралцах хугацааны хөдөлмөр эрхлэлт .....	72
6.2 Суралцах хугацаанд хийсэн дадлага .....	75
6.3 Одоогийн үндсэн ажлаас өмнөх хөдөлмөр эрхлэлт .....	78
БҮЛЭГ 7. ЦААШДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	83
7.1 Ирээдүй төлөвлөгөө, дахин суралцах байдал .....	84
ДҮГНЭЛТ .....	87
САНАЛ, ЗӨВЛӨМЖ .....	89

## ӨМНӨХ ҮГ

Хөдөлмөрийн нийлүүлэлтийн томоохон бүлгийг их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллгын төгсөгчид бүрдүүлдэг бөгөөд тэдний сургуулиас хөдөлмөрийн зах зээлд шилжих шилжилт, түүний онцлог, шинж чанарыг цогцоор судлах нь бодлого боловсруулагчдад шаардлагатай суурь мэдээллийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой.

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа нь үндэсний хэмжээнд төлөөлөх чадвартай томоохон түүвэр судалгаа бөгөөд уг судалгааг Хөдөлмөрийн судалгааны институт 2013 оноос 2020 оныг хүртэл жил бүр зохион байгуулж, төгсөгчдийг 4 жилийн хугацаад мөшгөн судалсан байдаг. 2021 оноос 2024 онд завсарласны эцэст 2025 онд дахин эхлүүлж байна.

Энэ удаагийн судалгаанд 2023-2024 оны хичээлийн жилд дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага төгссөн нийт төгсөгчдөөс түүвэрлэн хамруулж, тэдний хөдөлмөр эрхлэлтийн байдал, ур чадварын нийцэл, тулгамдсан асуудлыг судаллаа.

Та бүхэн судалгааны дүн, тайлантай танилцан, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглахын зэрэгцээ судалгааны арга, аргачлал, дүн шинжилгээтэй холбоотой санал хүсэлтээ бидэнд илгээж, хамтран ажиллахыг хүсье.

ЗАХИРАЛ



М.БАТГЭРЭЛ

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Эх олонлогийн ерөнхий мэдээлэл .....	17
Хүснэгт 2. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчид, ЭЗҮА-ны салбар, сургуулийн төрлөөр /хувь/ .....	37
Хүснэгт 3. Гэрээтэй хөдөлмөр эрхэлж буй эсэх, ЭЗҮА-ны салбараар /хувь/ .....	40
Хүснэгт 4. Эрхэлж буй ажил болон эзэмшсэн мэргэжлийн нийцэл, сургуулийн төрлөөр /хувь/ .....	46
Хүснэгт 5. Ажлын байран дахь ерөнхий ур чадварын хомсдол, сургуулийн төрлөөр /хувь/ .....	49
Хүснэгт 6. Ажлын байрны сэтгэл ханамжийн үнэлгээ /хувь/ .....	51
Хүснэгт 7. Ажлын байр сонгоход нөлөөлдөг хүчин зүйлс /хувь/ .....	64
Хүснэгт 8. Ажилд орохын тулд гаргаж буй хичээл зүтгэл, сургуулийн төрөлд эзлэх хувийн жингээр /хувь/ .....	65
Хүснэгт 9. Ажил хайх явцад гардаг хүндрэл бэрхшээл /хувь/ .....	66

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийн бүдүүвч .....	24
Зураг 2. Төгсөгчдийн насны бүлэг, сургуулийн төрлөөр .....	26
Зураг 3. ИДС төгсөгчдийн суралцаж төгссөн боловсролын түвшин /хувь/ .....	27
Зураг 4. МБСБ төгсөгчдийн суралцаж төгссөн боловсролын түвшин /хувь/ .....	27
Зураг 5. ИДС төгсөгчдийн эзэмшсэн үндсэн мэргэжлийн чиглэлээр /хувь/ .....	28
Зураг 6. ИДС төгсөгчдийн сургуулийн өмчийн хэлбэрээр /хувь/ .....	28
Зураг 7. МБСБ төгсөгчдийн эзэмшсэн үндсэн мэргэжлийн чиглэлээр /хувь/ .....	29
Зураг 8. МБСБ төгсөгчдийн сургуулийн өмчийн хэлбэрээр /хувь/ .....	29
Зураг 9. Төгсөгчдийн өмнөх болон одоогийн мэргэжлийн нийцэл, сургуулийн төрлөөр /хувь/ .....	30
Зураг 10. Төгссөн сургуулийг сонгон суралцсан шалтгаан, сургуулийн төрлөөр /хувь/ .....	31
Зураг 11. Төгсөгчдийн мэргэжил сонголтын шалтгаан /хувь/ .....	31
Зураг 12. Сургалтын төлбөрөө төлсөн байдал, сургуулийн төрлөөр /хувь/ .....	32
Зураг 13. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, сургуулийн төрлөөр /хувь/ .....	34
Зураг 14. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд /хувь/ .....	34
Зураг 15. ИДС төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжлээр /хувь/ .	35
Зураг 16. МБСБ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжлээр /хувь/ .	36
Зураг 17. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн ажлын байрны хэлбэр /хувь/ .....	38
Зураг 18. Бизнес эрхлэгч төгсөгчдийн ажилтан хөлслөлтийн байдал, сургуулийн төрлөөр /хувь/ .....	38
Зураг 19. Хөдөлмөрийн гэрээний хугацаа хязгаарлагдмал байгаа шалтгаанууд, сургуулийн төрлөөр /хувь/ .....	41
Зураг 20. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн орлогын албан татварын төлөлтийн байдал, сургуулийн төрлөөр /хувь/ .....	42
Зураг 21. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн даатгал, татварын хамрагдалт, сургуулийн төрлөөр /хувь/ .....	43

Зураг 22. Төгсөгчдийн ажиллаж буй байгууллагын хэлбэр, сургуулийн төрлөөр /хувь/ .....	44
Зураг 23. Эзэмшсэн боловсрол, АБ-нд шаардагдах боловсролын түвшний нийцэл /хувь/ .....	44
Зураг 24. АБ-нд шаардагдах ур чадвар, эзэмшсэн ур чадварын нийцэл /хувь/ .....	45
Зураг 25. ИДС төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт мэргэжлийн чиглэлээр /хувь/ .....	46
Зураг 26. МБСБ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт мэргэжлээр /хувь/ .....	47
Зураг 27. Төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллахгүй байгаа шалтгаан, сургуулийн төрлөөр /хувь/ .....	48
Зураг 28. Суралцах хугацаандаа олж авсан мэдлэг ур чадварын хэрэглээ, ашиглалт /хувь/ .....	48
Зураг 29. Ажлын байран дахь мэргэжлийн мэдлэг, ур чадварын хомсдол, сургуулийн төрөлд эзлэх /хувь/ .....	50
Зураг 30. Төгсөгчдийн ажил хайсан хугацаа, сургуулийн төрлөөр /хувь/ .....	50
Зураг 31. Төгсөгчид ажлын байрны мэдээллээ авч буй хэлбэр, сургуулийн төрлөөр /хувь/ .....	52
Зураг 32. Хувиараа бизнес эрхлэхэд тулгарсан хүндрэл, бэрхшээл /хувь/ .....	53
Зураг 33. Хувийн бизнес эхлүүлэхэд нөлөөлсөн хүчин зүйлс /хувь/ .....	54
Зураг 34. Төгсөгчдийн цалингийн хэлбэр, сургуулийн төрлөөр /хувь/ .....	56
Зураг 35. Хөдөлмөр эрхэлж буй ИДС төгсөгчдийн сарын дундаж цалин, мэргэжлийн чиглэлээр /сая төг/ .....	57
Зураг 36. Хөдөлмөр эрхэлж буй МБСБ төгсөгчдийн сарын дундаж цалин, мэргэжлийн чиглэлээр /сая төг/ .....	58
Зураг 37. Ажилгүй иргэн, сургуулийн төрлөөр, байршлаар /хувь/ .....	62
Зураг 38. Ажилгүй байгаа ИДС төгсөгчид, мэргэжлийн чиглэлээр /хувь/ .....	62
Зураг 39. Ажилгүй байгаа МБСБ төгсөгчид, мэргэжлийн чиглэлээр /хувь/ .....	63
Зураг 40. Ажилгүйдлийн шалтгаан /хувь/ .....	64
Зураг 41. Сүүлийн 30 хоногт ажил олох, бизнес эрхлэх гэж оролдоогүй шалтгаан /хувь/ .....	67
Зураг 42. Хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлаа өөрчлөх хүсэл, сургуулийн төрлөөр /хувь/ .....	67

Зураг 43. ИДС төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлөө өөрчлөх шалтгаан /хувь/ .....	68
Зураг 44. МБСБ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлөө өөрчлөх шалтгаан /хувь/ .....	68
Зураг 45. Ажлаа солихоор төлөвлөж буй ИДС төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийн чиглэл /хувь/ .....	69
Зураг 46. Давхар ажил хийж буй шалтгаан, сургуулийн төрлөөр /хувь/ ..	70
Зураг 47. Төгсөгчдийн суралцах хугацаандаа хөдөлмөр эрхлэх гол шалтгаан /хувь/ .....	73
Зураг 48. Төгсөгчдийн суралцах хугацаанд ажил эрхэлснээр эзэмшсэн ур чадвар /хувь/ .....	74
Зураг 49. Суралцах хугацаанд эзэмшсэн ур чадваруудын ажлын байранд ашиглагдаж буй байдал, сургуулийн төрлөөр /хувь/ .....	74
Зураг 50. Төгсөгчдийн суралцах хугацаанд мэргэжлийн дадлага хийсэн байдал, сургуулийн төрлөөр /хувь/ .....	75
Зураг 51. Төгсөгчдийн дадлага хийх хугацаанд олж авсан мэдлэг, ур чадвар ажлын байранд ашиглагдаж буй байдал /хувь/ .....	76
Зураг 52. Дадлагын хугацаа практик ур чадвар эзэмшихэд хангалттай байсан эсэх, сургуулийн төрлөөр /хувь/ .....	76
Зураг 53. Төгсөгчдийн дадлага хийсэн байгууллагаасаа үндсэн ажилтнаар үлдэх авсан санал байдал /хувь/ .....	77
Зураг 54. Төгсөгчдийн дадлага хийсэн байгууллагыг олсон эх үүсвэр /хувь/ .....	77
Зураг 55. Сургуулиа төгссөний дараах хөдөлмөр эрхлэлтийн байдал, сургуулийн төрлөөр /хувь/ .....	79
Зураг 56. Одоогийн ажлаас өмнөх хөдөлмөр эрхлэлтийн статус /хувь/ ...	80
Зураг 57. Одоогийн ажлаас өмнөх эрхэлж байсан ажлын байрны хэлбэр /хувь/ .....	80
Зураг 58. Төгсөгчдийн өмнөх ажлын байрнаас гарахад нөлөөлсөн хүчин зүйлс, сургуулийн төрлөөр /хувь/ .....	81
Зураг 59. Төгсөгчдийн ойрын нэг жилийн төлөвлөгөө /хувь/ .....	84
Зураг 60. Цаашид суралцах төлөвлөгөөтэй байгаа төгсөгчдийн шалтгаан /хувь// .....	85
Зураг 61. Өмнө эзэмшсэн мэргэжлээс өөр чиглэлээр суралцах гол шалтгаан /хувь/ .....	86

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХАХНХССХ	Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ИДС	Их, дээд сургууль
МБТБ	Мэргэжлийн болон техникийн боловсрол
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ILO	International Labour Organization
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ҮАМАТ	Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт
ЭЗБТҮАСА	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
АХС	Ажиллах хүчний судалгаа
ХАОСТ	Хүн ам, орон сууцны тооллого
АХОТ	Ажиллах хүчний оролцооны түвшин
ХЭТ	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгааны зорилго нь их, дээд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл дэх өөрчлөлт, ур чадварын нийцэл, түүнчлэн ажлын байранд тулгарч буй бэрхшээл, ажилгүй байгаа шалтгаан зэргийг бодитойгоор илрүүлэн, салбарын бодлого боловсруулагчид, их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын шийдвэр гаргагчид, судлаачдыг тоон мэдээллээр хангахад оршино.

Судалгаанд 2023-2024 оны хичээлийн жилд их, дээд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг мэргэжлийн анхан шатны болон түүнээс дээш бакалаврын боловсрол эзэмшин, төгссөн 44.8 мянган төгсөгчдийг төлөөлүүлэн 5407 төгсөгчдийг сонгон судалсан юм.

Судалгааны эх олонлогийн хувьд 59.8 хувь буюу 27.2 мянга нь их, дээд сургуулийг өдрийн бакалаврын анги, 40.2 хувь буюу 17.6 мянга нь мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшсэн төгсөгчид байна.

2023-2024 оны хичээлийн жилд суралцаж төгссөн төгсөгчдийг боловсролын түвшнээр авч үзвэл нийт төгсөгчдийн 50.3 хувь нь бакалавр, 20.2 хувь нь техникийн боловсрол, 14.5 хувь нь мэргэжлийн боловсрол, 8.2 хувь нь магистр, 4.7 хувь нь мэргэжлийн сургалт, 2.1 хувь нь дипломын боловсролын түвшинд суралцаж төгссөн байна.

Судалгааны дүнгээр нийт төгсөгчдийн 85.8 хувь нь ажиллах хүч, 14.3 хувь нь ажиллах хүчнээс гадуурх төгсөгчид байна. Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхтэй төгсөгчдийн 66.6 хувь нь Улаанбаатарт, 34.4 хувь нь орон нутагт амьдарч байна. Нийт төгсөгчдийн 81.3 хувь нь хөдөлмөр эрхэлж, 4.4 хувь нь ажилгүй, 14.3 хувь нь ажиллах хүчнээс гадуур буюу эдийн засгийн идэвхгүй байна. Сургуулийн төрлөөр үзвэл ИДС төгсөгчдийн 86.5 хувь нь, МБСБ төгсөгчдийн 73.7 хувь нь эдийн засгийн идэвхтэй байгаа бол ИДС төгсөгчдийн 13.5 хувь нь, МБСБ төгсөгчдийн 26.3 хувь нь ажиллах хүчнээс гадуур байгаа төгсөгчид байна.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийг ЭЗҮА-ны салбараар авч үзвэл 12.8 хувь нь боловсролын, 12.5 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны, 10.3 хувь нь хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа, 9.1 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт ажиллаж байна.

Сургуулийн төрлөөр нь тодруулбал ИДС төгссөн ажиллагчдын 17.5 хувь нь боловсролын, 14.8 хувь нь хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа, 11.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны, 10.1 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, 8.5 хувь нь санхүү болон даатгалын салбарт, МБСБ төгссөн ажиллагчдын 14.5 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны, 12.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 11.2 хувь нь барилгын, 10.3 хувь нь тээврийн салбарт ажиллаж байна.

Төгсөгчид ажил олгогчтой гэрээ байгуулж ажиллах нь ажлын байр баталгаатай байх үндэс болдог. Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн 87.3 хувь нь ямар нэг гэрээ байгуулан ажиллаж байна. Харин ИДС төгсөгчдийн 93.0 хувь нь МБСБ төгсөгчдийн 75.0 хувь нь ажил олгогчтойгоо гэрээ байгуулсан байна. МБСБ төгсөгчдийн 4 хүн тутмын 1 нь гэрээгүй байгуулахгүй ажиллаж байна. Хөдөлмөрийн харилцааны хувьд ИДС төгсөгчдийн дийлэнх нь хөдөлмөрийн гэрээ байгуулж, нийгмийн даатгалд хамрагдсан албан ёсны ажлын байранд ажиллаж байгаа бол МБСБ төгсөгчдийн дунд гэрээгүй ажиллах, нийгмийн даатгалд хамрагдаагүй байх зэрэг албан бус хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр харьцангуй өндөр байна.

ИДС төгсөгчдийн дийлэнх хувь нь эзэмшсэн мэргэжлийн чиглэлээрээ хөдөлмөр эрхэлж байна. Тухайлбал инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламжийн чиглэлээр төгсөгчдийн 89.0 хувь, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр төгсөгчдийн 88.9 хувь, хөдөө аж болон боловсролын чиглэлээр төгсөгчдийн 88.6 хувь нь мэргэжлийн дагуу ажиллаж байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт юм. Харин байгалийн шинжлэх ухаан, математик статистикийн чиглэлээр төгсөгчдийн 26.4 хувь, нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүйн чиглэлээр төгсөгчдийн 23.2 хувь, урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр төгсөгчдийн 22.4 хувь нь мэргэжлийн бус ажил эрхэлж байгаа нь бусад чиглэлтэй харьцуулахад харьцангуй өндөр байна.

МБСБ төгсөгчдийн 73.7 хувь хөдөлмөр эрхэлж байгаагийн 59.8 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байна. Боловсрол (92.3%), цагдаа, батлан хамгаалах, онцгой байдлын салбарт (90.9%), санхүү, бизнес, худалдааны салбарт (80.0%) хөдөлмөр эрхэлж буй төгсөгчид эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах нь бусад мэргэжлийн чиглэлтэй харьцуулахад өндөр байна. Харин мэдээлэл технологи, шуудан харилцаа холбоо, хот байгуулалт, үйлчилгээ зэрэг зарим салбарт мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэх хувь бусад мэргэжлийн чиглэлтэй харьцуулахад өндөр байна. Хөдөлмөрийн зах зээлийн шингээлт багатай мэргэжлээр элсэлт авч байгаа эсэх, тухайн ажлын байранд ур чадварын зөрүү гарч байгаа эсэхэд, мэргэжил сонголтын алдаа байгаа эсэхийг нарийвчлан судалж, анхаарал хандуулах хэрэгтэй.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчид мэргэжлээрээ ажиллахгүй байгаа шалтгаануудыг сургуулийн төрлөөр авч үзвэл, аль аль бүлэгт хөдөлмөрийн зах зээл дээрх ажлын байрны хүртээмж болон цалин хөлсний хүчин зүйлс голлон нөлөөлж байна. МБСБ төгсөгчдийн 15.0 хувь, ИДС төгсөгчдийн 21.9 хувийг “цалин хөлс бага” гэсэн шалтгаан эзэлж байна. Мөн эзэмшсэн мэргэжлээр ажлын байр олдохгүй байх шалтгаан МБСБ төгсөгчдийн 13.1 хувь, ИДС төгсөгчдийн 14.7 хувийг эзэлж байна.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн дийлэнх нь цалин хөлстэй ажилтан хэлбэрээр ажиллаж байгаа бөгөөд тодорхой хувь нь хувиараа бизнес эрхэлж байна. Сургуулийн төрлөөр авч үзвэл МБСБ төгсөгчдийн дунд хувиараа хөдөлмөр эрхлэх болон жижиг бизнес эрхлэх хувь ИДС төгсөгчдөөс харьцангуй өндөр байна.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 43.7 хувь нь ажлын байранд гарахад хүндрэл бэрхшээл тулгараагүй, 19.9 хувь нь төгсөхөөсөө өмнө ажиллаж байсан тул хүндрэл гараагүй гэж үзжээ. Харин тулгарсан хүндрэлүүдийн дундаас цалин хангалтгүй, тогтворгүй байх (14.3%), ажлын цаг урт, амралт чөлөө авах боломж бага (11.3%), ажлын ачаалал их, ажлын хуваарилалт шударга бус (7.2%) зэрэг асуудлууд харьцангуй өндөр хувийг эзэлж байна.

Төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээлд дасан зохицох нөхцөлийг сайжруулахын тулд ажлын байрны цалин хөлсний тогтвортой байдал, ажлын цагийн уян хатан зохицуулалт, байгууллагын дэмжлэгт орчныг сайжруулах нь зүйтэй.

Сургуулиа төгсөөд хувийн бизнес эрхлэхэд тулгарч буй хүндрэл нь 30.6 хувь нь зээл, санхүүжилт авах боломж хомс зээлийн хүү өндөр, бизнес эхлүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт хангалтгүй, 23.8 хувь нь орлогын тогтворгүй байдал, 12.4 хувь нь санхүү, татвар болон хууль эрх зүйн мэдлэг дутмаг, 11.0 хувь нь татвар шимтгэлийн ачаалал өндөр зэрэг хүндрэлүүд тулгарч байна.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 23.6 хувь нь давхар хөдөлмөр эрхэлж байна. Сургуулийн төрлөөр харвал хөдөлмөр эрхэлж буй ИДС төгсөгчдийн 23.9 хувь нь, МБСБ төгсөгчдийн 23.6 хувь нь давхар ажил хийж байна. Төгсөгчдийн дөрөвний нэг орчим нь нэмэлт орлого олох идэвхтэй оролдлого хийсэн байгаа нь орлогын нэмэгдэл эх үүсвэр шаардлагатай байна.

Одоогийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлаа өөрчлөхийг хүссэн хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн хувьд илүү цалинтай ажилд орох нь хамгийн гол шалтгаан болж байгаа бөгөөд ИДС төгсөгчдийн 43.4 хувь нь илүү цалинтай ажилд орох, 15.8 хувь нь ур чадвараа сайжруулах, 12.0 хувь нь ажлын бусад нөхцөл байдлыг сайжруулах, 7.5 хувь нь тогтвортой баталгаатай ажлын байртай болох зэрэг шалтгаанууд зонхилж байна.

Төгсөгчдийн 69.4 хувь нь суралцах хугацаандаа цалин, хөлстэй хөдөлмөр эрхэлж байсан бөгөөд ихэнх нь хичээлийн хажуугаар хагас цагийн ажил болон амралтын үеэр ажиллах хэлбэрээр хөдөлмөр эрхэлсэн байна. Төгсөгчид ажил эрхлэх гол шалтгаан нь хэрэглээний мөнгөө өөрөө олох, сургалтын төлбөрөө төлөх, орлого хуримтлал бий болгох зэрэг санхүүгийн хэрэгцээтэй холбон тайлбарласан байна. Мөн тодорхой хэсэг нь мэргэжлийн туршлага хуримтлуулах, ур чадвараа хөгжүүлэх зорилгоор ажил хийжээ.

Суралцах хугацаандаа ажил эрхэлснээр төгсөгчдөд харилцааны чадвар, цагийн менежмент, ажлын сахилга бат, асуудлыг бие даан шийдвэрлэх зэрэг хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай ур чадварууд түлхүү хөгжсөн байна. Эдгээр ур чадваруудын хувьд төгсөгчдийн ихэнх буюу 76.5 хувь нь одоогийн ажил үүргээ гүйцэтгэхэд хэрэг болж байна гэж үнэлсэн нь суралцах хугацаанд ажил эрхлэх нь бодит ажлын туршлага хуримтлуулах, хөдөлмөрийн зах зээлд дасан зохицоход чухал ач холбогдолтойг харуулж байна.

# БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

## 1.1 Судалгааны үндэслэл

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийг судлах нь хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулахад зайлшгүй шаардлагатай судалгааны чиглэл билээ. Төгсөгчдийн ажлын байранд шилжих хугацаа, мэргэжлээрээ ажиллаж буй эсэх, хөдөлмөрийн зах зээлд нийцсэн ур чадвар эзэмшсэн байдал зэрэг нь тухайн орны боловсролын чанар, бүтээмж, эдийн засгийн өсөлтийн хэтийн төлөвтэй шууд холбоотой үзүүлэлтүүд болдог. Тэдний хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийг цаг тухайд нь бодитоор нарийвчлан судлах нь улс орны хөдөлмөрийн зах зээлд урт хугацааны төлөвлөлт хийх, нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад чухал үндэс суурь болдог.

Тиймээс залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн багц асуудлыг судлан тодорхойлох, төрөлжсөн судалгааг гүйцэтгэх, ялангуяа хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн талын томоохон бүлэг болох их дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчдийн судалгааг хийх нь чухал ач холбогдолтой юм.

## 1.2 Судалгааны зорилго

Дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн сургуулиас ажлын байранд шилжих явц, тулгамдаж буй асуудал, хөдөлмөр эрхлэлт, түүний шинж чанар, хөдөлмөрийн харилцаа, мэргэжил болон ур чадварын нийцэл, ажилгүйдлийн шалтгаан зэргийн зүй тогтлыг тодорхойлох залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн бодлого боловсруулах суурь мэдээллээр салбарын бодлого боловсруулагчид, сургалтын байгууллагын удирдлагууд, судлаачид, хэрэглэгчдийг хангахад энэхүү судалгааны зорилго оршино.

### Судалгааны зорилт

- Төгсөгчдийн мэргэжил болон сургуулийн сэтгэл ханамжийг судлах;
- Сургуульд суралцах болон дараах хугацааны хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлыг судлах;
- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг ажлын байрны хэлбэр, статус, ажлын цаг, хөдөлмөрийн хөлс, үйл ажиллагааны чиглэл зэрэг олон талаас нь задлан судалж, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн онцлогийг тодорхойлох;
- Төгсөгчдийн мэргэжил, боловсрол, ур чадварын нийцэл, ажлын байранд шилжихэд тулгарч буй нийтлэг бэрхшээлийг тодорхойлох;
- Ажилгүй байгаа шалтгаан, ажил хайж буй хэлбэр, тулгамдаж буй асуудал, ажилгүйдлийн үргэлжлэх хугацааг тодорхойлох;

- Судалгааны үр дүнд тулгуурлан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, боловсрол болон хөдөлмөрийн салбарын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах бодлогын санал зөвлөмж боловсруулах.

### 1.3 Судалгааны түүврийн эх олонлог, хүрээ

2023-2024 оны хичээлийн жилд Монгол Улсын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагыг төгссөн нийт 44,890 төгсөгч нь түүврийн эх олонлогийг бүрдүүлнэ.

#### Хүснэгт 1. Эх олонлогийн ерөнхий мэдээлэл

2023-2024 оны хичээлийн жил	Тоо	Түүврийн хэмжээ
Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага	76	76
Дээд боловсролын сургалтын байгууллага	64	64
<b>Нийт</b>	<b>140</b>	<b>140</b>
Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөгчид	17655	2400
Дээд боловсролын сургалтын байгууллага төгсөгчид	27235	3600
<b>Нийт</b>	<b>44890</b>	<b>6000</b>

### 1.4 Судалгааны зохион байгуулалт

#### 1.4.1 Асуулгын хуудасны бүтэц

Уг судалгааны асуулга нь нийт 6 үндсэн бүлэг, 159 асуултаас бүрдэнэ.

- 1-р бүлэгт Хүн ам зүйн мэдээлэл
- 2-р бүлэгт Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт
- 3-р бүлэгт Хөдөлмөр эрхлэлтийн орлого
- 4-р бүлэгт Ажил хайх үйл явц
- 5-р бүлэгт Өмнөх үеийн хөдөлмөр эрхлэлт
- 6-р бүлэгт Цаашдын төлөвлөгөө

#### 1.4.2 Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг CSPRO программыг ашиглан гүйцэтгэсэн бөгөөд үр дүнг нэгтгэж, боловсруулалт хийхэд STATA программыг ашигласан.

## 1.5 Ойлголт, тодорхойлолт

Уг судалгаанд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг тодорхойлохдоо ҮСХ-ны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/09/08 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг мөрдөж байна.

Ажил, мэргэжлийн мэдээлэлд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 16 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт 08”-ын 2022 оны А/210 тушаалаар батлагдсан нэмэлт, өөрчлөлт оруулсныг ашигласан. Олон Улсын Ажил, мэргэжлийн Стандарт Ангилал (ISCO-08)-ын үзэл баримтлал, суурь зарчим, бүтцийг авч боловсруулсан манай улсын “YAMAT-08” нь 10 үндсэн бүлэгтэй, тэдгээр нь 43 дэд бүлэг, 130 бага бүлэг, 432 нэгж бүлгээс бүрдэх шаталсан бүтэцтэй байдаг.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын мэдээлэлд Сангийн сайд, үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 319, А/160 тушаалаар шинэчлэн баталсан Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ЭЗБТУАСА)-ыг ашигласан. Тус ангилалд 21 үндсэн салбар, тэдгээр нь 88 дэд салбар, 238 бүлэг, 420 ангиас бүрдэх шаталсан бүтэцтэй байдаг.

Тайланд дурдагдаж буй нэр томъёог дараах байдлаар ойлгоно.

**Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага** нь техникийн боловсролын, мэргэжлийн боловсролын, мэргэжлийн сургалтын гэсэн ангилалтай байна.

- Техникийн боловсролын сургалтын байгууллага нь политехник коллеж байна;
- Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь мэргэжлийн боловсролын сургууль байна;
- Мэргэжлийн сургалтын байгууллага нь сургалтын төв байна.

**Дээд боловсролын сургалтын байгууллага** нь коллеж, дээд сургууль, их сургууль байна.

- Их сургууль нь дэд бакалавр, бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгаа, туршилт-үйлдвэрлэлийн байгууллага байна;
- Дээд сургууль нь сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулж, дэд бакалавр, бакалавр, магистрын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгааны байгууллага байна;

- Коллеж нь дэд бакалавр, бакалавр, магистрын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт-судалгаа, сургалт-үйлдвэрлэлийн байгууллага байна.

**Төгсөгч:** 2023-2024 оны хичээлийн жилд их, дээд сургууль болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багц цагийг ханган, төгсөлтийн шалгалтад тэнцэн, бакалаврын диплом, магистрын диплом, техникийн боловсрол эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэх авсан иргэнийг хэлнэ.

**Хөдөлмөр эрхлэлт:** Цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа юм.

**Ажлын байр:** Цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан хийж гүйцэтгэх ажил, үүрэг, албан тушаалыг хэлнэ.

**Үндсэн ажлын байр:** Тухайн хүн цалин хөлс, орлого олох зорилгоор хоёр болон түүнээс дээш ажлын байранд хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд тухайн хугацаанд хамгийн их цаг зарцуулсан ажил юм.

**Эдийн засгийн үйл ажиллагаа:** Зах зээлд зориулж үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээ юм. Өөрөөр хэлбэл, үндэсний тооцооны системийн хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд худалдах, солилцох эсвэл өөрийн хэрэглээндээ зориулан өрхөд үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хамруулна.

**Ажиллах хүч:** Тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.

**Ажиллах хүчнээс гадуурх хүн ам:** Сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно.

**Ажиллагч** гэж зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ. Хөдөлмөр эрхлэгчдийг ажлын байрандаа байгаа болон түр эзгүй байгаа гэж хоёр бүлэгт хувааж авч үзнэ.

**Ажлын байрандаа байгаа ажиллагч** гэж тухайн хугацаанд цалин хөлс, орлого олох зорилгоор нэгээс дээш цагаар ажилласан хүн юм. Мөн улирлын шинж чанартай ажлынхаа улирлын үйл ажиллагаанаас хамааралгүйгээр, сул зогсолтын үеэр ч тогтмол ажилладаг ажиллагчдыг хамруулна.

**Ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагч** гэж хүндэтгэн үзэх болон сургалтад хамрагдах шалтгааны улмаас түр хугацаагаар чөлөөтэй байсан, ээлжийн ажилтай, амралтын цагаа нөхөж авах шалтгааны улмаас амарч байгаа, жирэмсний болон амаржсаны, жилийн ээлжийн амралттай байсан, нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдээр амарч байсан, ажил хаялт, ажлын байр түр хаалт, ажлын түр зогсолттой байсан учир тухайн хугацаанд “ажлын байрандаа байгаагүй” боловч эзгүй үед нь ажлын байр нь хадгалагдаж байгаа ажиллагчдыг хамруулна.

**Хөдөлмөр эрхлэлтийн статус** гэж эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа тухайн ажиллагчийг ажиллаж байгаа эдийн засгийн нэгж (хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага эсэх) болон эрх мэдэл, ажил үүргээр нь ангилахыг ойлгоно.

**Ажил олгогч** гэж ашиг олох зорилгоор тогтмол хугацаанд нэг буюу түүнээс дээш хүнийг “цалин хөлстэй ажиллагч”-аар ажиллуулдаг хувиараа хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийг ойлгоно.

**Цалин хөлстэй ажилтангүй бие даасан ажиллагч** гэж өөрийн хөрөнгөөрөө бие даан, эсвэл бусадтай хамтран эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж, тухайн хугацаанд ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулаагүй хувиараа хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийг ойлгоно. Ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулаагүй гэдэг нь өөрөөсөө, бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүнээсээ өөр нэг ч хүн ажилчнаар авч ажиллуулаагүй байхыг ойлгоно.

**Цалин хөлстэй ажиллагч** гэж ажиллаж буй эдийн засгийн нэгжээ эзэмшдэггүй, үйл ажиллагааны шийдвэрт оролцохгүйгээр тухайн нэгжид албан болон албан бусаар хөдөлмөр эрхлэн, ажилласан цаг, хийж гүйцэтгэсэн ажлынхаа (зарим тохиолдолд хийж гүйцэтгэсэн ажлынхаа үйл ажиллагаа тус бүрд) эсвэл худалдаа, үйлчилгээ (тоо хэмээ, захиалгын тоогоор) үзүүлснийхээ төлбөр болгон мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авдаг ажиллагч юм.

**Цалин хөлстэй байнгын ажиллагч** гэж ажлын цагийн доод хэмжээгээр ажиллах нь хүлээн зөвшөөрөгдсөн, байнгын буюу тухайн эдийн засгийн нэгжид ажиллах насны дээд хязгаар, тэтгэвэрт гарах нас зэргээс бусад хөдөлмөр эрхлэлтийг зогсоох тодорхой хугацаа, нөхцөл заагдаагүйгээр хөдөлмөр эрхэлдэг ажиллагч юм.

**Цалин хөлстэй түр ажиллагч** гэж хөдөлмөр эрхлэх хугацаа нь 3 ба түүнээс дээш сараар хязгаарлагдсан буюу тодорхой хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм.

**Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч** гэж ажлын тогтсон цаггүй, хөдөлмөр эрхлэлт нь 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлагдсан буюу богино хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм.

**Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан, дагалдан дадлагажигчид** гэж цалин хөлстэйгөөр, ажлын байрны болон мэргэжлийн хувьд дадлага, туршлага, ур чадвар эзэмших зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй ажиллагч юм.

**Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн** гэж өрхийн гишүүд, мөн өөр өрхөд амьдарч буй гэр бүлийн холбоотой (эцэг, эх, ах, дүү гэх мэт) хүмүүсийн эрхэлж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажилд, эсвэл тэдгээрийн цалинтай ажил болон гүйцэтгэх гэрээлэгчээр ажиллаж буй ажилд нь тусалж байгаа ажиллагчийг хэлнэ.

**Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч** гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно.

**Ажилгүй хүн** гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм.

- а. Хөдөлмөр эрхлээгүй гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн ажил хийгээгүй, ажиллагч гэдэг тодорхойлолтод хамаарахгүй байхыг;
- б. Ажил хийхэд бэлэн гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт эсвэл тухайн хугацаанаас хойш ирэх хоёр долоо хоногт ажил хийж эхлэхэд бэлэн байхыг;
- в. Ажил хайж байгаа гэж сүүлийн дөрвөн долоо хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн хэлбэрээр ажил хайсан эсвэл хувийн бизнес эхлүүлэх оролдлого хийсэн хүн юм.

**Боломжит ажиллах хүч** гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм.

**Итгэл алдарсан ажил хайгч** гэж ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой байгаа хүн ам (тодорхойлолт 2.16.б)-аас хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой буюу мэргэжил, туршлага байхгүйгээс тохирох ажлын байр олж авч чадахгүй байгаагаас эсвэл хэтэрхий залуу, хөгшин байна гэсэн шалтгаанаар ажил олгогчдын шаардлагад нийцэхгүй байгаагаас ажлын 16 байр хайж олох найдвараа алдан, ажил хайгаагүй байгаа хөдөлмөрийн насны хүн ам юм.

**Албан бус салбар** гэж хөдөө аж ахуйн бус салбарт орлого олох зорилготойгоор зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ борлуулдаг өрхийн хоршоологдоогүй аж ахуй нэгжийг ойлгоно.

**Албан бус хөдөлмөр эрхлэгч** гэж албан бус ажлын байранд хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм. Албан бус хөдөлмөр эрхлэгчид дараах хүмүүсийг хамааруулна.

Үүнд:

- а. Тухайн хугацаанд хөдөлмөрийн харилцаа нь хууль эрх зүйн хүрээнд бүрэн зохицуулагдаагүй, орлогын албан татвар, өвчтэй байсны тэтгэмж, ээлжийн амралт олгодоггүй, нийгмийн хамгааллын бусад асуудал хангагдаагүй нөхцөлд ажиллаж буй цалин хөлстэй ажиллагч;
- б. Албан бус салбарт ажиллаж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч болон цалин хөлстэй ажиллагчгүй бие даасан ажиллагч;
- г. Зөвхөн өөрийн эцсийн хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй өрхөд цалин хөлстэй ажиллагч;
- д. Хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүд орно.

**Байнгын ажлын цаг** гэж богино хугацаанд буюу нэг долоо хоног, урт хугацаанд буюу сар, улирал, эсвэл жилийн турш тухайн ажилд ажилласан ердийн цагийг ойлгоно. Жишээлбэл, тухайн хүний сүүлийн сарын долоо хоног бүрд хамгийн их ажилласан цаг, мөн ажлын цагийн хуваарийн дагуу долоо хоногт ажиллах цагийг авч үзэж болно.

**Бүтэн цагаар ажиллагч** гэж Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай хууль”-д заасны дагуу долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл, ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг, ажлын дараалсан 2 өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цаг ба түүнээс дээш хугацаатай ажилладаг ажиллагч болон ээлжээр ажилладаг ажиллагчийг ойлгоно.

**Ажил хийгээгүй болон суралцаагүй байгаа залуучууд** гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй, албан боловсрол эзэмших сургуульд суралцаагүй, бүх шатны сургалтад хамрагдаагүй байгаа 15-24 насны ажилгүй болон ажиллах хүчнээс гадуурх залуучуудыг ойлгоно.

**Ажиллах хүч:** Тухайн хугацаанд хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүний тооны нийлбэрээр тооцно.

$$\text{Ажиллах хүч} = \text{Ажиллагчид} + \text{Ажилгүй хүн}$$

**Өргөтгөсөн ажиллах хүч:** Ажиллах хүч болон боломжит ажиллах хүчний тооны нийлбэрээр тооцно.

$$\text{Өргөтгөсөн ажиллах хүч} = \text{Ажиллах хүч} + \text{Боломжит ажиллах хүч}$$

**Хөдөлмөр эрхлэлтийн түвшин:** Ажиллагчдын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Хөдөлмөр эрхлэлтийн түвшин} = \frac{(\text{Ажиллагчдын тоо})}{(\text{Хөдөлмөрийн насны хүн ам})} \times 100\%$$


**Ажилгүйдлийн түвшин:** Ажилгүй хүний тоог ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно.

$$\text{ХДАТ}_1 = \frac{(\text{Ажилгүй хүний тоо})}{(\text{Ажиллах хүч})} \times 100\%$$

**Цалин хөлстэй эмэгтэй, эрэгтэй ажиллагчдын цагийн дундаж цалин хөлс:** Цалин хөлс дэх жендэрийн зөрүүтэй байдлаар илэрхийлэгдэх бөгөөд нийт ажиллагчдаас зөвхөн цалин хөлстэй бие даасан эрэгтэй болон эмэгтэй ажиллагчдын цагийн дундаж цалин хөлсний зөрүүг эрэгтэй ажиллагчдын цагийн дундаж цалинд харьцуулж тооцно.

$$\frac{\text{Цалин хөлстэй эмэгтэй, эрэгтэй ажиллагчдын цагийн дундаж цалин хөлс}}{\text{Цагийн дундаж цалин хөлс эрэгтэй} - \text{Цагийн дундаж цалин хөлс эмэгтэй}} \times 100\%$$

Зураг 1. Хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийн бүдүүвч





## БҮЛЭГ 2. ТӨГСӨГЧДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ




## 2.1 Төгсөгчдийн хүн ам зүйн төлөв байдал

Судалгаанд 2023-2024 оны хичээлийн жилд их, дээд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг мэргэжлийн анхан шатны болон түүнээс дээш, бакалаврын боловсрол эзэмшин төгссөн 44.8 мянган төгсөгчдийг төлөөлүүлэн 6000 төгсөгчдийг түүвэрлэн, судалгаанд хамруулсан. Хүндэтгэн үзэх шалтгаан буюу гадаад явсан, холбоо хэрэгсэл нь өөрчлөгдсөн, татгалзсан зэрэг шалтгаанаар нийт 5407 төгсөгч судалгаанд хамрагдсан.

Судалгааны эх олонлогийн 59.8 хувь буюу 27.4 мянга нь ИДС-ийг өдрийн бакалаврын анги, 40.2 хувь буюу 17.6 мянга нь мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшсэн төгсөгчид байсан. Төгсөгчдийн 43.4 хувь нь эрэгтэй, 56.6 хувь нь эмэгтэй бол сургуулийн төрлөөр, ИДС төгсөгчдийн 65.5 хувь, МБСБ төгсөгчдийн 42.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Судалгаанд оролцогчдын дундаж нас 26 байна. ИДС төгсөгчдийн дундаж нас 27, МБСБ төгсөгчдийн дундаж нас 26 байна. Насны бүтцийн хувьд нийт оролцогчдын 56.3 хувь нь 15–24 насныхан, 25.1 хувь нь 25–34 насныхан, харин 18.6 хувь нь 35 ба түүнээс дээш насныхан байна.

Зураг 2. Төгсөгчдийн насны бүлэг, сургуулийн төрлөөр



Гэрлэлтийн байдлын хувьд төгсөгчдийн 57.0 хувь нь гэрлээгүй, 26.5 хувь нь гэр бүлээ батлуулсан, 15.2 хувь нь гэрлэсэн боловч батлуулаагүй гэжээ. Ам бүлийн тоог бүлэглэн үзвэл 35.9 хувь нь 3 хүртэл, 23.6 хувь нь 4, 40.5 хувь нь 5 ба түүнээс олон ам бүлтэй өрхөд амьдарч байгаа ба ам бүлийн дундаж тоо 4 байна.


2023-2024 оны хичээлийн жилд суралцаж төгссөн төгсөгчдийг боловсролын түвшнээр авч үзвэл нийт төгсөгчдийн 50.3 хувь нь бакалавр, 20.2 хувь нь техникийн боловсрол, 14.5 хувь нь мэргэжлийн боловсрол, 8.2 хувь нь магистр, 4.7 хувь нь мэргэжлийн сургалт, 2.1 хувь нь дипломын боловсролын түвшинд суралцаж төгссөн байна.

Зураг 3. ИДС төгсөгчдийн суралцаж төгссөн боловсролын түвшин /хувь/



ИДС төгсөгчдийн 83.0 хувь нь бакалавр, 13.5 хувь нь магистр зэрэгтэй төгссөн байна.

Зураг 4. МБСБ төгсөгчдийн суралцаж төгссөн боловсролын түвшин /хувь/



МБСБ төгсөгчдийн 51.3 хувь нь техникийн, 36.9 хувь нь мэргэжлийн боловсрол, 11.8 хувь нь мэргэжлийн сургалтын хөтөлбөрөөр төгссөн байна. Төгсөгчдийн тал илүү хувь нь техникийн боловсрол эзэмшсэн байна.

## 2.2 Төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийн чиглэл

2023-2024 оны хичээлийн жилд ИДС төгсөгчдийн 32.2 хувь нь бизнес, удирдлага, хууль, эрх зүй, 18.0 хувь нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, 14.5 хувь нь боловсрол, 11.5 хувь нь инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламжийн мэргэжлийн чиглэлээр төгсөгчид байгаа нь дийлэнх хувийг эзэлж байна.

ИДС төгсөгчдийн дийлэнх нь бизнес, удирдлага, хууль, эрх зүйн чиглэлээр төгссөн бөгөөд энэ нь бусад мэргэжлийн чиглэлүүдээс хамгийн өндөр хувийг эзэлж байна. Харин байгалийн шинжлэх ухаан, математик, статистик болон хөдөө аж ахуйн чиглэлээр төгсөгчдийн эзлэх хувь хамгийн бага байгаа нь эдгээр салбарт төгсөгчдийн тоо харьцангуй цөөн байгааг харуулж байна.

### Зураг 5. ИДС төгсөгчдийн эзэмшсэн үндсэн мэргэжлийн чиглэлээр /хувь/



ИДС төгсөгчдийн 66,5 хувь нь төрийн, 31,5 хувь нь хувийн өмчийн сургуулийн төгсөгчид байна. Төрийн өмчийн сургууль 25.3 хувь, хувийн өмчийн сургууль төгсөгчдийн 47,7 хувь нь бизнес, удирдлагын мэргэжлийн чиглэлээр төгссөн байгаа бөгөөд бараг хоёр төгсөгч тутмын нэг нь дээрх чиглэлээр мэргэжил эзэмшиж байна.

### Зураг 6. ИДС төгсөгчдийн сургуулийн өмчийн хэлбэрээр /хувь/



Хөдөлмөрийн зах зээлд бизнес, удирдлагын чиглэлийн төгсөгчид (ялангуяа хувийн сургуулиас) хэт олширч байна. Харин хөдөө аж ахуй зэрэг үйлдвэрлэлийн салбарын мэргэжилтнүүд хангалтгүй бэлтгэгдэж байна.


МБСБ төгсөгчдийн дийлэнх нь үйлдвэрлэл, дэд бүтцийн чиглэлээр төгссөн байна. Тухайлбал, 27.2 хувь нь аж үйлдвэрийн чиглэлээр, 19.0 хувь нь барилгын чиглэлээр, 12.9 хувь нь тээврийн чиглэлээр төгссөн байна. Харин боловсрол, эрчим хүч, хот байгуулалт зэрэг зарим чиглэлд төгсөгчдийн эзлэх хувь харьцангуй бага байна.

**Зураг 7. МБСБ төгсөгчдийн эзэмшсэн үндсэн мэргэжлийн чиглэлээр /хувь/**



МБСБ төгсөгчдийн 54.5 хувь нь төрийн өмчийн, 24.5 хувь нь хувийн өмчийн, 20.8 хувь нь орон нутгийн өмчийн сургуулиудын төгсөгчид байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт төрийн өмчийн байгууллагууд төгсөгч бэлтгэхэд голлох байр суурьтай байна. Үүний зэрэгцээ орон нутгийн өмчийн сургуулиуд нийт төгсөгчдийн тодорхой хувийг бэлтгэж байгаа нь орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээг хангах, бүс нутгийн хөгжлийг дэмжихэд чухал ач холбогдолтой байна.

**Зураг 8. МБСБ төгсөгчдийн сургуулийн өмчийн хэлбэрээр /хувь/**



■ Төрийн өмчийн МБСБ ■ Хувийн өмчийн МБСБ ■ Орон нутгийн өмчийн МБСБ

Нийт төгсөгчдийн 30.8 хувь нь хоёр ба түүнээс дээш мэргэжлийн зэрэгтэй байна. Сургуулийн төрлөөр харвал ИДС төгсөгчдийн 25.7 хувь нь, МБСБ төгсөгчдийн 38.6 хувь нь давхар мэргэжлийн зэрэг эзэмшсэн байна. МБСБ төгсөгчдийн дунд давхар мэргэжил эзэмшсэн хувь ИДС төгсөгчдөөс өндөр байгааг харуулж байна. Давхар мэргэжил эзэмшсэн төгсөгчдийн хувь тодорхой хэмжээгээр байх нь тэдний мэргэжлийн хүрээг тэлж, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж байна.

*Зураг 9. Төгсөгчдийн өмнөх болон одоогийн мэргэжлийн нийцэл, сургуулийн төрлөөр /хувь/*




### 2.3 Төгсөгчдийн сургууль болон мэргэжлийн талаарх үнэлэмж

Энэ бүлэгт төгсөгчдийн төгссөн сургууль болон эзэмшсэн мэргэжил, төгссөн сургуулийг сонгосон шалтгаан, сургуулийн талаарх сэтгэл ханамжийн түвшин, үргэлжлүүлэн суралцагчидтай холбоотой үр дүнг танилцуулах болно.

Их, дээд сургуулийн төгсөгчид сургуулийн эрэмбэ өндөр, чанартай боловсрол олгодог зэргээс хамаарч сургууль сонголтыг хийдэг бол мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчид сонирхсон мэргэжил зөвхөн энэ сургуульд байдгаас гадна эцэг эх, багш нарын зөвлөгөөг дагасан гэсэн шалтгааныг илүү онцолсон байна.

**Зураг 10. Төгссөн сургуулийг сонгон суралцсан шалтгаан, сургуулийн төрлөөр /хувь/**



Төгсөгчид эзэмшсэн мэргэжлээ хэрхэн сонгосон, өөрөөр хэлбэл тэдний мэргэжил сонголтод нөлөөлсөн гол хүчин зүйлсийг судлан үзсэн. ИДС болон МБСБ нийт төгсөгчдийн 53.9 хувь нь сонирхсон мэргэжлийн дагуу тухайн сургуульд элсэн суралцсан байхад 13.3 хувь нь ажлын байрны олдоц сайн, 9.4 хувь нь цаашид хөгжих боломж сайн, эцэг эх, багш нарын зөвлөгөөг дагасан зэрэг шалтгаанаар сургуулиа сонгон суралцсан байна.

Мэргэжил сонголтын шалтгааны талаарх мэдээлэлд дээд болон мэргэжлийн боловсролын сургуулийн төгсөгчдөд ялгаа байгаа эсэхийг үзэхэд аль аль нь сонирхсон мэргэжлийн дагуу сонгосон нь зонхилж байна.

**Зураг 11. Төгсөгчдийн мэргэжил сонголтын шалтгаан /хувь/**




Нийт төгсөгчдөөс эзэмшсэн мэргэжилдээ хэр сэтгэл ханамжтай байгааг тодруулахад 42.7 хувь нь маш хангалуун, 40.5 хувь нь хангалуун, 14.2 хувь нь дунд зэрэг, 2.6 хувь нь сэтгэл ханамжгүй гэж хариулсан байна. Сургуулийн төрлөөр харвал ИДС төгсөгчдийн 82.0 хувь нь, МБСБ төгсөгчдийн 85.0 хувь нь эзэмшсэн мэргэжилдээ сэтгэл хангалуун байна.

Төгсөгчдийн сургалтын төлбөрийг хэрхэн төлсөн байдлыг сургуулийн төрлөөр авч үзэхэд ИДС төгсөгчдийн 39.7 хувь нь сургалтын төлбөрөө эцэг, эх, асран хамгаалагч болон бусад гишүүдээр төлүүлсэн бол 38.1 хувь нь өөрийн орлогоор төлсөн байна. Түүнчлэн 13.1 хувь нь тэтгэлэг, 4.9 хувь нь сургалтын төлбөрийн зээл, 1.5 хувь нь буцалтгүй тусламжаар суралцжээ. Харин 1.3 хувь нь үнэгүй суралцсан байна.

МБСБ төгсөгчдийн хувьд 40.5 хувь нь үнэгүй суралцсан нь хамгийн өндөр үзүүлэлт байна. 27.3 хувь нь өөрийн орлогоор, 21.0 хувь нь эцэг, эх гэр бүлийн дэмжлэгээр сургалтын төлбөрөө төлсөн бол 9.5 хувь нь тэтгэлэг, 0.9 хувь нь буцалтгүй тусламж, 0.2 хувь нь сургалтын зээл ашигласан байна.

Дээрхээс харахад ИДС-ийн төгсөгчид сургалтын төлбөрийг ихэвчлэн гэр бүлийн дэмжлэг болон өөрийн орлогоор сургалтын төлбөрөө төлдөг бол МБСБ-ын төгсөгчдийн дунд хөнгөлөлт (үнэгүй суралцах) зонхилж байна.

**Зураг 12. Сургалтын төлбөрөө төлсөн байдал, сургуулийн төрлөөр /хувь/**






**БҮЛЭГ 3. ТӨГСӨГЧДИЙН  
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**



Энэ бүлэгт төгсөгчдийн 2025 оны эдийн засгийн идэвхийг авч үзнэ. Судалгааны дүнгээр нийт төгсөгчдийн 85.8 хувь нь ажиллах хүч, 14.2 хувь нь ажиллах хүчнээс гадуурх төгсөгчид байна. Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхтэй төгсөгчдийн 66.6 хувь нь Улаанбаатарт, 34.4 хувь нь орон нутагт амьдарч байна.

Нийт төгсөгчдийн 81.3 хувь нь хөдөлмөр эрхэлж, 4.4 хувь нь ажилгүй, 14.3 хувь нь ажиллах хүчнээс гадуур буюу эдийн засгийн идэвхгүй байна. Сургуулийн төрлөөр үзвэл ИДС төгсөгчдийн 86.5 хувь нь, МБСБ төгсөгчдийн 73.7 хувь нь эдийн засгийн идэвхтэй байгаа бол ИДС төгсөгчдийн 13.5 хувь нь, МБСБ төгсөгчдийн 26.3 хувь нь ажиллах хүчнээс гадуур байгаа төгсөгчид байна.

*Зураг 13. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, сургуулийн төрлөөр /хувь/*



*Зураг 14. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд /хувь/*



### 3.1 Хөдөлмөр эрхлэлтийн шинж байдал

Тус судалгааны нэг зорилго нь төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулахад чиглэгдсэн. Тайлангийн энэ бүлэгт төгсөгчдийн тухайн үеийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулах юм.

Судалгааны дүнгээр нийт төгсөгчдийн 81.3 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаагийн 43.4 хувь нь эрэгтэйчүүд, 56.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Сургуулийн төрлөөр нь авч үзвэл ИДС төгсөгчдийн 86.5 хувь нь, МБСБ төгсөгчдийн 73.7 хувь нь тус тус хөдөлмөр эрхэлж байна.


ИДС төгсөгчдийн 13.7 хувь нь эрүүл мэндийн мэргэжилтэн, 13.1 хувь нь багшлах мэргэжилтэн, 10.4 хувь нь хууль, нийгмийн, соёлын мэргэжилтэн, 9.4 хувь нь бизнес, захиргааны мэргэжилтэн, 8.1 хувь нь шинжлэх ухаан, инженерийн мэргэжилтэн өндөр хувийг эзэлж байна.

Зураг 15. ИДС төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжлээр /хувь/



МБСБ төгсөгчдийн хувьд 8.6 хувь нь жолооч, хөдөлгөөнт тээврийн хэрэгслийн оператор, 7.9 хувь нь металл механизмтай холбоотой мэргэжлийн ажилтан, 7.7 хувь нь хувийн үйлчилгээний ажилтан, 7.6 хувь нь барилгын мэргэжлийн ажилтан, 7.6 хувь нь борлуулалтын ажилтан зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээ, техникийн чиглэлийн мэргэжлүүд өндөр хувийг эзэлж байна. Мөн хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, инженерийн туслах мэргэжлийн ангиллуудад тодорхой төвлөрөл ажиглагдаж байна.

*Зураг 16. МБСБ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжлээр /хувь/*



Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийг ЭЗҮА-ны салбараар авч үзвэл 12.8 хувь нь боловсролын, 12.5 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны, 10.3 хувь нь хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа, 9.1 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт ажиллаж байна.

Сургуулийн төрлөөр нь тодруулбал ИДС төгссөн ажиллагчдын 17.5 хувь нь боловсролын, 14.8 хувь нь хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа, 11.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны, 10.1 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, 8.5 хувь нь санхүү болон даатгалын салбарт, МБСБ төгссөн ажиллагчдын 14.5 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны, 12.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 11.2 хувь нь барилгын, 10.3 хувь нь тээврийн салбарт ажиллаж байна.


*Хүснэгт 2. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчид, ЭЗҮА-ны салбар, сургуулийн төрлөөр /хувь/*

<b>Эдийн засгийн үйл ажиллагааны салбар</b>	<b>ИДС төгсөгч</b>	<b>МБСБ төгсөгч</b>	<b>Бүгд</b>
Боловсрол	17.5	4.3	12.8
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	14.8	2.1	10.3
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	11.3	14.5	12.5
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	10.1	7.1	9.1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	8.5	0.3	5.6
Барилга	4.9	11.2	7.2
Боловсруулах үйлдвэрлэл	4.9	12.7	7.6
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	4.6	1.1	3.3
Уул уурхай, олборлолт	4.4	7.2	5.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3.8	3.2	3.6
Мэдээлэл, холбоо	3.5	1.0	2.6
Тээвэр	3.2	10.3	5.7
Урлаг, үзвэр, тоглоом наадам	2.4	1.9	2.2
Удирдлага болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.7	2.1	1.8
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1.4	9.2	4.2
Үйлчилгээ бусад үйл ажиллагаа	1.2	5.2	2.6
Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, загас барилт, ан агнуур	0.8	5.6	2.5
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.6	0.2	0.4
Ус хангамж; Сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.3	0.9	0.5
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.2	0.0	0.1
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 85.6 хувь нь цалин хөлстэй ажилтан, 14.4 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байна. Сургуулийн төрлөөр авч үзвэл ИДС төгсөгчдийн 87.1 хувь нь цалин хөлстэй ажилтан, 8.5 хувь нь хувийн бизнес эрхэлж байгаа МБСБ төгсөгчдийн 74.6 хувь нь цалин хөлстэй ажилтан, 19.3 хувь нь хувийн бизнес эрхлэгч байна.


Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн гол хэлбэр нь цалин хөлстэй ажилтнаар ажиллах хэлбэр байгаа бөгөөд МБСБ төгсөгчдийн хувьд хувиараа бизнес эрхлэх идэвх ИДС төгсөгчдөөс илүү байна.

*Зураг 17. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн ажлын байрны хэлбэр /хувь/*



Хөдөлмөр эрхлэлтийн нэг чухал хэлбэр нь хувиараа бизнес эрхлэх замаар өөртөө болон бусдад ажлын байр бий болгох чадамж юм. Судалгааны дүнгээс харахад хувиараа бизнес эрхэлж буй ИДС төгсөгчдийн 27.5 хувь нь тогтмол ажилтантай байгаа нь МБСБ төгсөгчидтэй (15.9%) харьцуулахад 11.6 пунктээр өндөр байна. Харин ИДС төгсөгчдийн 16.6 хувь, МБСБ төгсөгчдийн 21.2 хувь нь ажилтныг хааяа хөлсөлдөг бол, ИДС төгсөгчдийн 55.9 хувь, МБСБ төгсөгчдийн 63.0 хувь нь огт ажилтан хөлсөлдөггүй байна.

*Зураг 18. Бизнес эрхлэгч төгсөгчдийн ажилтан хөлслөлтийн байдал, сургуулийн төрлөөр /хувь/*



Төгсөгчид ажил олгогчтой гэрээ байгуулж ажиллах нь ажлын байр баталгаатай байх үндэс болдог. Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн 87.3 хувь нь хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. Харин ИДС төгсөгчдийн 93.0 хувь нь МБСБ төгсөгчдийн 75.0 хувь нь ажил олгогчтойгоо гэрээ байгуулсан байна. МБСБ төгсөгчдийн 4 хүн тутмын 1 нь гэрээгүй ажиллаж байна.

Байгалийн шинжлэх ухаан, бизнес, хууль эрх зүй, инженерчлэлийн чиглэлүүдэд хөдөлмөрийн харилцаа бүрэн гэрээний үндсэн дээр зохицуулагдсан бол боловсрол, санхүү, эрүүл мэнд, уул уурхайн салбаруудад гэрээтэй ажиллагчдын эзлэх хувь өндөр байна.

Харин үйлчилгээний бусад үйл ажиллагаа (31.1%), зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ (16.2%), барилга (12.3%), хөдөө аж ахуйн салбар (12.2%)-т гэрээгүй хөдөлмөр эрхлэлт харьцангуй өндөр байгаа нь эдгээр салбарт хөдөлмөрийн харилцааны зохицуулалт сул байна.

Барилга, зочид буудал, нийтийн хоол, хөдөө аж ахуйн салбаруудад аман гэрээтэй ажиллах хувь өндөр байгаа нь хөдөлмөрийн харилцааны тогтвортой байдал хангалтгүй байна.

*Хүснэгт 3. Гэрээтэй хөдөлмөр эрхэлж буй эсэх, ЭЗҮА-ны салбараар /хувь/*

<b>ЭЗҮА-ны салбар</b>	<b>Аман гэрээтэй</b>	<b>Гэрээтэй</b>	<b>Гэрээгүй</b>	<b>Бүгд</b>
Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик	0.0	100.0	0.0	100.0
Барилга	22.0	65.6	12.3	100.0
Бизнес, удирдахуй, хууль, эрх зүй	0.0	100.0	0.0	100.0
Боловсрол	1.3	97.8	0.9	100.0
Боловсруулах үйлдвэрлэл	13.3	76.6	10.1	100.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	10.5	80.6	8.9	100.0
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	14.4	69.3	16.2	100.0
Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	0.0	100.0	0.0	100.0
Мэдээлэл, холбоо	7.5	90.1	2.4	100.0
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	7.4	90.9	1.7	100.0
Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй	0.0	100.0	0.0	100.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0.8	97.8	1.4	100.0
Тээвэр	5.1	92.2	2.7	100.0
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2.1	89.9	8.0	100.0
Удирдлага болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	7.5	81.8	10.7	100.0
Урлаг, үзвэр, тоглоом наадам	11.1	76.5	12.3	100.0
Ус хангамж; Сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.0	89.2	10.8	100.0
Уул уурхай, олборлолт	4.4	93.5	2.1	100.0
Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, загас барилт, ан агнуур	13.8	74.0	12.2	100.0
Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлэг	0.0	100.0	0.0	100.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	6.9	88.8	4.3	100.0
Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	3.1	94.9	2.1	100.0
Үйлчилгээ бусад үйл ажиллагаа	7.8	61.1	31.1	100.0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	7.1	92.9	0.0	100.0
Бүгд	6.1	87.6	6.3	100.0


Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй төгсөгчдийн 20.1 хувь нь хугацаатай, 79.9 хувь нь хугацаагүй гэрээ байгуулан ажиллаж байна.

Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээ нь байнгын бус, тодорхой хугацаагаар хязгаарлагдаж буй үндсэн шалтгаануудыг ИДС болон МБСБ төгсөгчдийн сургуулийн төрлөөр харьцуулан авч үзвэл, гэрээний хугацаа хязгаарлагдмал байгаа хамгийн гол шалтгаан нь хууль журмаас шалтгаалсан (ИДС 33.9%, МБСБ 29.1%) байна.

ИДС төгсөгчдийн 20.8 хувь нь, МБСБ төгсөгчдийн 17.8 хувь нь энгийн ажил эрхэлж байгаа нь гэрээний хугацаа хязгаартай байх гол үндэслэл болж байна. МБСБ төгсөгчдийн 16.9 хувь нь, ИДС төгсөгчдийн 5.4 хувь нь улирлын шинж чанартай байна. Улирлын шинж чанартай ажил эрхлэх хандлага МБСБ төгсөгчдийн хувьд ИДС төгсөгчдөөс 3 дахин их байна.

Судалгааны үр дүнгээс харахад ИДС төгсөгчдийн хувьд гэрээ хязгаарлагдмал байгаа нь голдуу түр зуурын шинжтэй энгийн ажил байгаатай холбоотой бол МБСБ төгсөгчдийн хувьд салбарын онцлогоос шалтгаалсан улирлын ажил давамгайлж байна.


*Зураг 19. Хөдөлмөрийн гэрээний хугацаа хязгаарлагдмал байгаа шалтгаанууд, сургуулийн төрлөөр /хувь/*



Хөдөлмөрийн гэрээ нь тодорхой хугацаагаар хязгаарлагдсан төгсөгчдийн хувьд гэрээний үргэлжлэх хугацааг ИДС болон МБСБ сургуулийн төрлөөр авч үзвэл, ИДС төгсөгчдийн 58.9 хувь нь 1 жил ба түүнээс дээш гэрээний хугацаатай байгаа нь МБСБ төгсөгчдөөс (44.2%) илүү байна. ИДС төгсөгчдийн 21.4 хувь нь, МБСБ төгсөгчдийн 22.2 хувь нь 6 сараас 1 жил хүртэлх хугацаатай гэрээ байгуулсан байна. МБСБ төгсөгчдийн 13.3 хувь нь, ИДС төгсөгчдийн 6.6 хувь нь 3 сарын хугацаатай гэрээтэй ажиллаж байна. Гэрээний хугацаанаас харахад ИДС төгсөгчдөд илүү урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах хандлагатай байна. Харин МБСБ төгсөгчдийн хувьд 3-6 сарын хугацаатай богино болон дунд хугацааны гэрээт ажил эрхлэлт түгээмэл байна.

Төгсөгчдийн цалин хөлснөөс орлогын албан татвар суутгаж буй байдал нь тэдний хөдөлмөр эрхлэлтийн албан ёсны байдлыг илэрхийлэх чухал үзүүлэлт юм. Хөдөлмөр эрхэлж буй нийт төгсөгчдийн 82.2 хувь нь цалингаасаа орлогын албан татвар суутгуулдаг бол 14.7 хувь татвар суутгуулдаггүй байна. 3.1 хувь нь татвар суутгуулдаг эсэхээ мэдэхгүй байна.

*Зураг 20. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн орлогын албан татварын төлөлтийн байдал, сургуулийн төрлөөр /хувь/*




Сургуулийн төрлөөр авч үзвэл, ИДС төгсөгчдийн 91.1 хувь нь, МБСБ төгсөгчдийн 63.3 хувь цалингаасаа орлогын албан татвар суутгуулдаг байна. ИДС төгсөгчдийн 6.7 хувь нь, МБСБ төгсөгчдийн 31.8 хувь нь орлогын албан татвар суутгуулдаггүй байна.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн болон ажилгүйдлийн даатгал төлөлтийн байдлыг авч үзвэл 86.4 хувь нь төлдөг, 12.0 хувь нь төлдөггүй, 1.5 хувь нь төлдөг эсэхээ мэдэхгүй байна. ИДС төгсөгчид 94.1 хувь, МБСБ 70.2 хувьтай байна.

ИДС төгсөгчдийн дийлэнх хувь нь даатгал төлж байгаа нь тэдний хөдөлмөрийн харилцаа хамгийн өндөр байгааг харуулж байна. Харин МБСБ төгсөгчдийн 27.0 хувь нь даатгал төлдөггүй байгаа нь 4 хүн тутмын 1 нь нийгмийн хамгааллын гадна үлдэх эрсдэлтэй байгааг илтгэж байна.

**Зураг 21. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн даатгал, татварын хамрагдалт, сургуулийн төрлөөр /хувь/**




ИДС төгсөгчдийн дийлэнх хувь нь даатгал төлж байгаа нь тэдний хөдөлмөрийн харилцаа хамгийн өндөр байгааг харуулж байна. Харин МБСБ төгсөгчдийн 27.0 хувь нь даатгал төлдөггүй байгаа нь 4 хүн тутмын 1 нь нийгмийн хамгааллын гадна үлдэх эрсдэлтэй байгааг илтгэж байна. Судалгааны дүнгээс харахад хөдөлмөр эрхэлж буй ИДС төгсөгчдийн 84.1 хувь, МБСБ төгсөгчдийн 54.6 хувь нь амралтын мөнгөө бодуулж, жилийн ээлжийн амралтаа авч байна. Харин ээлжийн амралтын мөнгөө бодуулж авдаггүй гэж хариулсан МБСБ төсөгчдийн (39.6%) ИДС төгсөгчдөөс (12.1%) 3 дахин өндөр байна. Энэ нь ИДС төгсөгчид хөдөлмөрийн хуульд заасан баталгаагаар илүү хангагдсан ажлын байранд ажиллаж байгааг харуулж байна.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн ажиллаж буй байгууллагын хариуцлагын хэлбэрийг авч үзвэл ИДС болон МБСБ төгсөгчдийн аль аль нь голчлон төсөвт байгууллага болон хязгаарлагдмал хариуцлагатай компанид ажиллаж байна. ИДС төгсөгчдийн 34.7 хувь нь төсөвт байгууллагад, 32.4 хувь нь хязгаарлагдмал хариуцлагатай компанид ажиллаж байгаа нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Харин МБСБ төгсөгчдийн хувьд 30.3 хувь нь хязгаарлагдмал хариуцлагатай компанид, 18.4 хувь нь хувьцаат компанид, 17.8 хувь нь төсөвт байгууллагад тус тус ажиллаж байна.

МБСБ төгсөгчид өрхийн аж ахуй (11.3%) болон албан ёсны бүртгэлгүй орлоготой хэлбэрээр (6.4%) ажиллах нь ИДС төгсөгчдөөс харьцангуй өндөр байна. Харин ИДС төгсөгчдийн хувьд төрийн өмчит үйлдвэрийн газар (4.4%) болон төрийн бус байгууллагад (3.7%) ажиллах хувь арай өндөр байна.

**Зураг 22. Төгсөгчдийн ажиллаж буй байгууллагын хэлбэр, сургуулийн төрлөөр /хувь/**




### 3.2 Мэргэжил, боловсрол, ур чадварын нийцэл

Эзэмшсэн боловсролын түвшин болон ажлын байранд шаардагдах боловсролын түвшин ихэнх тохиолдолд нийцэж байна. Нийт төгсөгчдийн 66.7 хувь нь эзэмшсэн боловсрол нь ажлын байранд тохиромжтой гэж үзсэн бол 12.1 хувь нь эзэмшсэн боловсролоос доогуур шаардлагатай ажлын байранд, 13.7 хувь нь эзэмшсэн боловсролоос илүү шаардлага бүхий ажлын байранд ажиллаж байна.


Сургуулийн төрлөөр авч үзвэл ИДС төгсөгчдийн 71.1 хувь нь эзэмшсэн боловсролын түвшин ажлын байранд тохиромжтой гэж хариулсан нь МБСБ төгсөгчдөөс (58.9%) харьцангуй өндөр байна. Харин МБСБ төгсөгчдийн 18.4 хувь нь эзэмшсэн боловсролоос доогуур шаардлагатай ажлын байранд ажиллаж байгаа бол ИДС төгсөгчдийн хувьд энэ үзүүлэлт 8.5 хувь байна. Мөн ИДС төгсөгчдийн 15.9 хувь нь эзэмшсэн боловсролоос илүү шаардлага бүхий ажлын байранд ажиллаж байгаа нь МБСБ төгсөгчдөөс (9.8%) илүү байна. ИДС төгсөгчдийн эзэмшсэн боловсролын түвшин ажлын байрны шаардлагатай илүү нийцэж байгаа бол МБСБ төгсөгчдийн хувьд боловсрол, ажлын байрны шаардлагын нийцлийг сайжруулах, шаардлагатай байна.

**Зураг 23. Эзэмшсэн боловсрол, АБ-нд шаардагдах боловсролын түвшний нийцэл /хувь/**



Эзэмшсэн боловсрол, ажлын байрны нийцэл, ажлын байранд ороход нөлөөлсөн хүчин зүйлсээс гадна ажлын байранд шаардагдах ур чадварын шаардлага, суралцах хугацаандаа эзэмшсэн ур чадвар хоорондын нийцлийг 4 түвшнээр хэмжсэн.

*Зураг 24. АБ-нд шаардагдах ур чадвар, эзэмшсэн ур чадварын нийцэл /хувь/*



Төгсөгчдийн ажлын байрны ур чадварын шаардлага, эзэмшсэн ур чадвартай харьцуулахад 66.2 хувь нь тохиромжтой, 14.4 хувь өндөр, гэсэн бол 13.2 хувь нь доогуур, 6.1 хувь хэлж мэдэхгүй байна.

Зарим төгсөгчид өөрийн эзэмшсэн боловсрол, ур чадварын түшинг ажлын байрны шаардлагаас доогуур гэж үнэлсэн нь ажилтан, ажил олгогчийн шаардлагад тэнцэхгүй объектив, хувь хүний хүчин зүйлстэй холбоотой субъектив шалтгаантай байж болох ч боловсролын байгууллагуудын сургалтын чанарыг харуулах хэмжүүр байж болох талтай

Төгсөгчид эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байгаа эсэхийг тандах зорилгоор ажил үүрэг, эзэмшсэн мэргэжлийн нийцтэй байдлын талаар асууж, огт тохирдоггүйгээс маш тохиромжтой хүртэл 1-5 баллаар үнэлүүлсэн. Хөдөлмөр эрхэлж буй нийт төгсөгчдийн 33.1 хувь нь маш тохиромжтой, 42.1 хувь нь тохиромжтой гэж үзсэн бол 24.8 хувь нь тохирдоггүй буюу мэргэжлийн бус хөдөлмөр эрхэлж байна. Эрхэлж буй ажил нь эзэмшсэн мэргэжилтэй хэр нийцэж байгааг сургуулийн төрлөөр авч үзвэл, ИДС төгсөгчдийн 44.9 хувь нь мэргэжилдээ тохирсон, 39.0 хувь нь маш тохиромжтой ажил эрхэлж байгаа бол 8.7 хувь нь тохиромжгүй, 5.7 хувь нь огт тохиромжгүй гэж үзсэн байна.

Харин МБСБ төгсөгчдийн хувьд 37.1 хувь нь тохиромжтой, 22.7 хувь нь маш тохиромжтой ажил эрхэлж байгаа бол 21.2 хувь нь тохиромжгүй, 16.1 хувь нь огт тохиромжгүй гэж хариулсан байна.

Төгсөгчдийн дийлэнх хувь нь эзэмшсэн мэргэжилтэйгээ нийцсэн ажил эрхэлж байгаа хэдий ч МБСБ төгсөгчдийн дунд мэргэжилтэйгээ нийцэхгүй ажил эрхлэх хувь ИДС төгсөгчдөөс илүү байгаа нь харагдаж байна.

*Хүснэгт 4. Эрхэлж буй ажил болон эзэмшсэн мэргэжлийн нийцэл, сургуулийн төрлөөр /хувь/*

Сургуулийн төрөл	Огт тохиромжгүй	Тохиромжгүй	Тохиромжтой	Маш тохиромжтой	Хэлж мэдэхгүй байна	Бүгд
ИДС төгсөгч	5.7	8.7	44.9	39	1.8	100
МБСБ төгсөгч	16.1	21.2	37.1	22.7	3	100
Бүгд	9.4	13.1	42.1	33.2	2.2	100

ИДС төгсөгчдийн дийлэнх хувь нь эзэмшсэн мэргэжлийн чиглэлээрээ хөдөлмөр эрхэлж байна. Тухайлбал инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламжийн чиглэлээр төгсөгчдийн 89.0 хувь, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр төгсөгчдийн 88.9 хувь, хөдөө аж болон боловсролын чиглэлээр төгсөгчдийн 88.6 хувь нь мэргэжлийн дагуу ажиллаж байна.

Харин байгалийн шинжлэх ухаан, математик статистикийн чиглэлээр төгсөгчдийн 26.4 хувь, нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүйн чиглэлээр төгсөгчдийн 23.2 хувь, урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр төгсөгчдийн 22.4 хувь нь мэргэжлийн бус ажил эрхэлж байгаа нь бусад чиглэлтэй харьцуулахад харьцангуй өндөр байна.

*Зураг 25. ИДС төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт мэргэжлийн чиглэлээр /хувь/*




МБСБ төгсөгчдийн 73.7 хувь хөдөлмөр эрхэлж байгаа ба тэдгээрийн 59.8 хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байна. Боловсрол (92.3%), цагдаа, батлан хамгаалах, онцгой байдлын салбарт (90.9%), санхүү, бизнес, худалдааны салбарт (80.0%) хөдөлмөр эрхэлж буй төгсөгчид эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах нь бусад мэргэжлийн чиглэлтэй харьцуулахад өндөр байна. Харин мэдээлэл технологи, шуудан харилцаа холбоо, хот байгуулалт, үйлчилгээ зэрэг зарим салбарт мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэх хувь бусад мэргэжлийн чиглэлтэй харьцуулахад өндөр байна.

Зураг 26. МБСБ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт мэргэжлээр /хувь/




Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчид мэргэжлээрээ ажиллахгүй байгаа шалтгаануудыг сургуулийн төрлөөр авч үзвэл, аль аль бүлэгт хөдөлмөрийн зах зээл дээрх ажлын байрны хүртээмж болон цалин хөлсний хүчин зүйлс голлон нөлөөлж байна. МБСБ төгсөгчдийн 15.0 хувь, ИДС төгсөгчдийн 21.9 хувийг “цалин хөлс бага” гэсэн шалтгаан эзэлж байна. Мөн эзэмшсэн мэргэжлээр ажлын байр олдохгүй байх шалтгаан МБСБ төгсөгчдийн 13.1 хувь, ИДС төгсөгчдийн 14.7 хувийг эзэлж байна.

Зураг 27. Төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллахгүй байгаа шалтгаан, сургуулийн төрлөөр /хувь/



Зураг 28. Суралцах хугацаандаа олж авсан мэдлэг ур чадварын хэрэглээ, ашиглалт /хувь/



Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдөд суралцах хугацаандаа олж авсан мэдлэг нь тухайн ажлын байранд ажил үүргээ гүйцэтгэхэд тус болж чадаж байгаа эсэхийг тодруулахад 70.2 хувь нь тус болдог, 24.1 хувь нь зарим талаараа тус болдог 5.7 хувь нь тус болдоггүй гэж хариулсан.

Сургуулийн төрлөөр нь харвал МБСБ төгсөгчдийн 10.5 хувь нь, ИДС төгсөгчдийн 3.1 хувьд нь эзэмшсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар нь тухайн ажлын байранд ажил үүргээ гүйцэтгэхэд тус болоогүй гэжээ.

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн хамгийн ихээр нэрлэсэн тухайн ажлын байранд тулгардаг ерөнхий ур чадварын дутагдал нь багаар ажиллах, дасан зохицох, харилцааны, бие даан ажиллах, илтгэх өөрийгөө илэрхийлэх, шийдвэр гаргах зэрэг чадварууд байна. Сургуулийн төрлөөр нь авч үзэхэд ИДС төгсөгчдийн хувьд илтгэх, өөрийгөө илэрхийлэх багаар ажиллах, харилцааны, судалгаа хийх, мэдээлэл хайх, дүн шинжилгээ хийх чадвар, МБСБ төгсөгчдийн хувьд багаар ажиллах, харилцааны, бие даан ажиллах, цаг ашиглах чадварууд илүү дутагдаж байгаагаа илэрхийлжээ.

*Хүснэгт 5. Ажлын байран дахь ерөнхий ур чадварын хомсдол, сургуулийн төрлөөр /хувь/*

Ур чадвар	ИДС төгсөгч	МБСБ төгсөгч	Бүгд
Илтгэх, өөрийгөө илэрхийлэх ур чадвар	21.2	25.9	22.9
Харилцааны чадвар, хэрэглэгчтэй харилцах, хэлэлцээр хийх ур чадвар	14.7	16.0	15.2
Багаар ажиллах, дасан зохицох чадвар	14.0	12.0	13.3
Судалгаа хийх, мэдээлэл хайх, дүн шинжилгээ хийх чадвар	8.6	9.2	8.8
Бичгийн ур чадварууд	8.5	4.6	7.1
Бие даан ажиллах, бие даан шийдвэр гаргах чадвар	8.1	10.2	8.9
Цаг төлөвлөх/ашиглах чадвар, ажлын төлөвлөх чадвар	6.7	6.3	6.5
Үр дүнтэй олон ажил зэрэг хийх (multitasking) чадвар	5.5	5.5	5.5
Манлайлах, зохион байгуулах чадвар	5.1	3.8	4.7
Шүүмжлэлт сэтгэлгээ	4.1	2.6	3.6
Бусад	3.4	3.8	3.6
Бүгд	100.0	100.0	100.0

Ажиллаж буй ажлын байранд дутагдаж байгаа мэргэжлийн ур чадварыг харахад төгсөгчдийн дунд хамгийн ихээр дутагдаж буй ур чадвар нь гадаад хэлний мэдлэг байна. Тухайлбал, ИДС төгсөгчдийн 24.4 хувь, МБСБ төгсөгчдийн 19.5 хувь нь гадаад хэлний мэдлэг дутагдаж байна гэж үзсэн байна. Мэргэжлийн практик мэдлэг, ур чадвар харьцангуй өндөр хувьтай байгаа бөгөөд МБСБ төгсөгчдийн 17.1 хувь, ИДС төгсөгчдийн 16.5 хувь нь энэ чадвар дутмаг байгааг дурдсан байна.

Үүнээс гадна шинжлэх ухаан, технологи, компьютерын мэдлэг МБСБ төгсөгчдийн 11.1 хувь, ИДС төгсөгчдийн 9.3 хувьд дутагдаж байгаа нь орчин үеийн технологийн мэдлэгийг сайжруулах шаардлагатайг харуулж байна. МБСБ төгсөгчдийн хувьд мэргэжлийн нэр томъёог ойлгож, хэрэглэж сурах чадвар (11.4%) болон ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдлэг (9.7%) мэдлэг дутагдаж байгаа тул сургалтын агуулга, практик сургалтыг сайжруулахад анхаарах шаардлагатай байна. ИДС төгсөгчдийн хувьд оффис программ ашиглах чадвар (9.62%) болон баримт бичиг боловсруулах чадвар (6.6%) дутагдаж байна.


Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд гадаад хэлний мэдлэгийг илүү сайжруулах, харин их, дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрт мэргэжлийн англи хэл, практик ур чадвар, технологийн мэдлэгийг түлхүү хөгжүүлэх шаардлагатай байна.

**Зураг 29. Ажлын байран дахь мэргэжлийн мэдлэг, ур чадварын хомсдол, сургуулийн төрөлд эзлэх /хувь/**



Төгсөгчдийн дийлэнх нь төгсөх үедээ эсвэл богино хугацаанд ажлын байртай болж, хөдөлмөрийн зах зээлд харьцангуй хурдан шилжиж байна.

**Зураг 30. Төгсөгчдийн ажил хайсан хугацаа, сургуулийн төрлөөр /хувь/**



### 3.3 Ажлын байранд тулгарч буй асуудал, бэрхшээл

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 43.7 хувь нь ажлын байранд гарахад хүндрэл бэрхшээл тулгараагүй, 19.9 хувь нь төгсөхөөсөө өмнө ажиллаж байсан тул хүндрэл гараагүй гэж үзжээ. Харин тулгарсан хүндрэлүүдийн дундаас цалин хөлс хангалтгүй, ажлын байранд тогтворгүй байх (14.3%), ажлын цаг урт, амралт чөлөө авах боломж бага (11.3%), ажлын ачаалал их, ажлын хуваарилалт шударга бус (7.2%) зэрэг асуудлууд харьцангуй өндөр хувийг эзэлж байна.

Төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээлд дасан зохицох нөхцөлийг сайжруулахын тулд ажлын байрны цалин хөлсний тогтвортой байдал, ажлын цагийн уян хатан зохицуулалт, байгууллагын дэмжлэгт орчныг сайжруулах шаардлагатай байна.

Төгсөгчдийн ажлын байрны сэтгэл ханамжийг 9 үзүүлэлтээр 1-5 оноогоор үнэлүүлсэн.Төгсөгчид байгууллагын нэр хүнд, ажлын орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл (ХАБЭА)-д сэтгэл ханамж өндөр байна. Харин цалин, урамшуулал, ажлын цаг, ачаалал, ажил үүргийн хуваарилалт нь хамгийн бага үнэлгээтэй байна.

#### Хүснэгт 6. Ажлын байрны сэтгэл ханамжийн үнэлгээ

Хүчин зүйлс	МБСБ төгсөгч	ИДС төгсөгч	Бүгд
Байгууллагын нэр хүнд	4.4	4.2	4.3
Ажлын хамт олон, уур амьсгал, удирдлагын дэмжлэг	4.2	4.1	4.1
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	4.1	4.1	4.1
Ажил үүрэг, албан тушаалын нэр хүнд, ач холбогдол, ажлын үр дүн	4.2	4.1	4.1
Хувь хүний хөгжил, туршлага хуримтлуулах боломж	4.1	3.9	4.0
Ажлын орчин, байршил, ажлын байрны ая тух, техник хэрэгсэл	4.0	3.9	3.9
Бие даан шийдвэр гаргах, бүтээлчээр ажиллах боломж	4.0	3.9	3.9
Ажлын цаг, ачаалал, уян хатан байдал, ажил үүргийн хуваарилалт	3.8	3.7	3.7
Цалин, урамшуулал	3.8	3.5	3.6

Одоогийн эрхэлж буй ажлын байрны талаарх мэдээллийг ИДС төгсөгчдийн 31.2 хувь, МБСБ төгсөгчдийн 17.3 хувь нь эцэг эх, ах эгч нараасаа, ИДС төгсөгчдийн 16.7 хувь, МБСБ төгсөгчдийн 20.9 хувь нь найз нөхөд, дээд үеийн төгсөгчдөөс авсан байна. Сошиал медиагаас ИДС төгсөгчдийн 17.5 хувь, МБСБ төгсөгчдийн 15.8 хувь нь ажлын байрны мэдээллээ авсан бол ИДС төгсөгчдийн 16.3 хувь нь, МБСБ төгсөгчдийн 8.5 хувь нь ажил зуучлалын веб сайтаас мэдээлэл авсан байна.

Харин төрийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн бирж, ажлын байрны өдөрлөг зэрэг албан ёсны сувгуудын ашиглалт харьцангуй бага байгаа нь эдгээр сувгийн хүртээмж, үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Төгсөгчид ажлын байрны мэдээллийг албан ёсны эх сурвалжаас илүүтэйгээр хувийн танилын сүлжээ болон цахим орчноос авч байгаа бөгөөд хөдөлмөр зуучлалын албан ёсны тогтолцоо харьцангуй сул байна.

*Зураг 31. Төгсөгчид ажлын байрны мэдээллээ авч буй хэлбэр, сургуулийн төрлөөр /хувь/*




Сургуулиа төгсөөд хувийн бизнес эрхлэхэд тулгарч буй хүндрэл нь 30.6 хувь нь зээл, санхүүжилт авах боломж хомс, шалгуур өндөр, эхлэлийн хөрөнгө оруулалт хангалтгүй, 23.8 хувь нь орлогын тогтворгүй байдал, 12.4 хувь нь санхүү, татвар болон хууль эрх зүйн мэдлэг дутмаг, 11.0 хувь нь татвар шимтгэлийн ачаалал өндөр зэрэг хүндрэлүүд тулгарч байна.

*Зураг 32. Хувиараа бизнес эрхлэхэд тулгарсан хүндрэл, бэрхшээл /хувь/*



Хувийн бизнес эхлүүлэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл нь хувийн хүсэл, мөрөөдөл, зорилго байсан бөгөөд 26.3 хувь нь энэ шалтгааныг дурдсан бол 16.9 хувь нь ажлын цаг, амьдралын уян хатан байдал.

Зураг 33. Хувийн бизнес эхлүүлэхэд нөлөөлсөн хүчин зүйлс /хувь/





**БҮЛЭГ 4. ХӨДӨЛМӨР  
ЭРХЛЭЛТИЙН ОРЛОГО**




## 4.1 Хөдөлмөрийн орлого

Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдөөс үндсэн ажлаасаа цалин хөлс, урамшуулал зэрэг төлбөрийг ямар хэлбэрээр авч байгааг тодруулахад нийт төгсөгчдийн 90.3 хувь нь орлогоо мөнгөн хэлбэрээр авч байна. Харин 5.4 хувь нь мөнгөн бус хэлбэрээр орлого авч байгаа бол 4.3 хувь нь ямар нэгэн цалин, урамшуулал огт аваагүй.

Сургуулийн төрлөөр авч үзвэл, их, дээд сургууль (ИДС)-ийн төгсөгчдийн 89.5 хувь нь орлогоо мөнгөн хэлбэрээр авч байгаа бол мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага (МБСБ)-ын төгсөгчдийн хувьд энэ үзүүлэлт 92.2 хувьтай байна.

Мөнгөн бус хэлбэрээр орлого олсон болон огт орлогогүй төгсөгчдийн 61.4 хувь нь ямар нэгэн нэмэлт дэмжлэг, хангамж огт аваагүй. Харин үлдсэн хувь нь хувцас (22.9%), хоол хүнс (18.0%), тээврийн зардлын дэмжлэг (13.7%) зэрэг дэмжлэг авсан байна.


Зураг 34. Төгсөгчдийн цалингийн хэлбэр, сургуулийн төрлөөр /хувь/



Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн сарын дундаж цалин нь 2,4 сая мянган төгрөг байна. Сургуулийн төрлөөр нь харьцуулбал ИДС төгсөгчдийн сарын дундаж цалин нь 2,3 сая төгрөг бол МБСБ төгсөгчдийнх дундаж сарын цалин 2,0 сая төгрөг байна. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 7 хоногийн ажлын дундаж өдөр 5, ажлын дундаж цаг 43 нэмэлт ажлын цаг дунджаар 3 цаг байна. Төгсөгчдийн сарын дундаж ажлын өдөр 21 амралтын өдөр 9 байна.

Тухайлбал мэдээлэл харилцаа холбооны технологийн чиглэлээр төгсөгчдийн дундаж цалин хамгийн өндөр буюу 2,8 сая төгрөг байгаа бол бизнес, удирдлага, эрх зүйн чиглэлээр төгсөгчдийн дундаж цалин 2,4 сая төгрөг байна. Мөн инженерчлэл, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр төгсөгчдийн цалин харьцангуй өндөр түвшинд байна. Харин боловсрол болон эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр төгсөгчдийн дундаж цалин харьцангуй бага байна.

*Зураг 35. Хөдөлмөр эрхэлж буй ИДС төгсөгчдийн сарын дундаж цалин, мэргэжлийн чиглэлээр /сая төг/*



МБСБ төгсөгчдийн сарын дундаж цалинг салбараар авч үзвэл уул уурхайн салбарт ажиллаж буй төгсөгчдийн цалин хамгийн өндөр буюу 2,2 сая төгрөг байна. Үүний дараа тээврийн салбарт 2,1 сая төгрөг, хөдөө аж ахуйн салбарт 2,0 сая төгрөг, барилгын салбарт 1,9 сая төгрөгийн дундаж цалин авч байна.

Харин боловсролын салбарт ажиллаж буй төгсөгчдийн дундаж цалин 1,5 сая төгрөг, мэдээлэл технологийн салбарт 1,4 сая төгрөг, хот байгуулалт, тохижилтын салбарт 1,2 сая төгрөг, санхүү, бизнес, худалдааны салбарт 1,1 сая төгрөг байгаа нь бусад салбаруудтай харьцуулахад харьцангуй бага байна.

*Зураг 36. Хөдөлмөр эрхэлж буй МБСБ төгсөгчдийн сарын дундаж цалин, мэргэжлийн чиглэлээр /сая төг/*



Хувиараа хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн бизнесийн үйл ажиллагаанаас олж буй сарын цэвэр ашгийг авч үзвэл дунджаар 6,9 сая төгрөг байна. Орлогын түвшнээр авч үзэхэд 17.8 хувь нь 1,0 сая төгрөг хүртэлх орлоготой, 16.2 хувь нь 1,0-1,9 сая төгрөг, 15.9 хувь нь 3,0 - 4,9 сая төгрөгийн орлоготой байгаа нь харьцангуй өндөр хувийг эзэлж байна.

Орлого олж буй хугацааг авч үзвэл төгсөгчдийн 53.2 хувь нь сар бүр, 8.6 хувь нь долоо хоногт, 7.4 хувь нь хоёр долоо хоногт, 3.8 хувь нь өдөр бүр орлого олдог гэж хариулсан байна. Мөн 8.4 хувь улирлын төгсгөлд, 6.3 хувь нь жилд нэг удаа, 4.2 хувь нэг удаагийн үйлчилгээний хөлс хэлбэрээр орлого олдог байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь сар бүр тогтмол орлоготой боловч тодорхой хэсгийн орлого улирлын болон нэг удаагийн шинжтэй байна.

Тухайн орлого олсон хугацаанд бизнесийн үйл ажиллагаанд зарцуулж буй өдрийн тоог авч үзвэл 42.1 хувь нь 21–30 өдөр ажилладаг, 24.8 хувь нь 1–10 өдөр ажилладаг, 17.4 хувь нь 11–20 өдөр ажилладаг, 14.0 хувь нь 30-аас дээш өдөр ажилладаг байна. Нийт дүнгээр тухайн хугацаанд сарын дундаж ажлын 26 өдөр байна. Өдөрт ажилласан цагийг авч үзвэл ихэнх төгсөгчид 8–12 цагийн хооронд ажилладаг байна.

## **4.2 Орлогын ялгаатай байдал**

Судалгааны дүнгээс харахад хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн орлого нь хөдөлмөр эрхлэлтийн хэлбэрээс шалтгаалан ялгаатай байна. Цалинтай хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн орлого нь ихэвчлэн тогтмол хугацаанд цалин, хөлс хэлбэрээр олгогддог бол, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлого бизнесийн үйл ажиллагаанаас бий болсон цэвэр ашигт тулгуурлаж харьцангуй хэлбэлзэлтэй байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд орлого нь ихэвчлэн цэвэр ашгийн хэмжээгээр тодорхойлогдож байна. Орлогын түвшин багаас их хүртэл өргөн тархалттай бөгөөд зарим нь ашиггүй байгаа бол нөгөө хэсэг нь өндөр хэмжээний ашигтай байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлого тогтмол бус, бизнесийн үр ашиг, зах зээлийн нөхцөлөөс хамааралтай юм.

Орлого олох хугацааны хувьд мөн ялгаа ажиглагдаж байна. Цалинтай хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 75.3 хувь нь сард, 17.9 хувь нь хоёр долоо хоногт цалингаа авдаг байна. Харин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 53.2 хувь нь сар бүр, үлдсэн хэсэг нь долоо хоног, улирал, жил зэрэг өөр өөр хугацаагаар ашгаа тооцож байгаа нь орлого нь илүү уян хатан боловч тогтворгүй байгааг харуулж байна.

Цалинтай хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн орлогод зөвхөн цалин бус ажил олгогчоос олгож буй хангамж, урамшуулал тодорхой нөлөөтэй байна. Тухайлбал хоол хүнс, тээврийн зардал, зарим тохиолдолд орон сууц зэрэг дэмжлэг авдаг байна. Харин хувиараа хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн хувьд бизнесийн үйл ажиллагаанаас бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээ нь өрхийн хэрэглээнд ашиглах боломжтой байдаг нь мөнгөн бус орлогын шинжтэй үр өгөөж бий болгож байна.

Ажилласан цаг, хөдөлмөрийн ачааллын хувьд цалинтай хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн ихэнх нь өдөрт 8 цаг ажилладаг бол хувиараа хөдөлмөр эрхэлдэг төгсөгчдийн хувьд 8-12 цаг ажиллах тохиолдол өндөр байна. Хувиараа хөдөлмөр эрхэлдэг төгсөгчид илүү урт цаг ажилладаг байна.

Төгсөгчдийн орлогын ялгаатай байдлыг авч үзэхэд цалинтай хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн орлого илүү тогтвортой, тогтсон хугацаанд олгогддог, харин хувиараа хөдөлмөр эрхэлдэг төгсөгчдийн орлого илүү хэлбэлзэлтэй, эрсдэлтэй боловч өсөх боломж илүү байж болох юм.




## БҮЛЭГ 5. АЖИЛ ХАЙХ ЯВЦ



## 5.1 Ажил хайж буй хэлбэр, тулгамдаж буй асуудал

Нийт төгсөгчдийн 4.4 хувь нь ажилгүй, ажил идэвхтэй хайж байгаагаас 36.3 хувь нь эрэгтэйчүүд, 63.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Сургуулийн төрлөөр нь авч үзвэл МБСБ төгсөгчдийн 6.6 хувь нь, ИДС төгсөгчдийн 3.0 хувь нь ажилгүй байна.

Зураг 37. Ажилгүй иргэн, сургуулийн төрлөөр, байршлаар /хувь/



Ажилгүй иргэдийн 63.4 хувь нь нийслэлд, 36.6 хувь нь орон нутагт амьдарч байна. Сургуулийн төрлөөр нь харвал ажилгүй байгаа ИДС төгсөгчдийн 70.1 хувь нь нийслэлд, 29.9 хувь нь орон нутагт, МБСБ төгсөгчдийн 57.8 хувь нь нийслэлд, 42.2 хувь нь орон нутагт амьдарч байна.


Ажилгүй байгаа ИДС төгсөгчдийн бизнес удирдлага, хууль эрх зүйн мэргэжлийн чиглэлээр 31.9 хувь нь, эрүүл мэнд, нийгэм хамгааллын мэргэжлийн чиглэлээр 23.7 хувь нь, боловсролын чиглэлээр төгсөгчдийн 14.8 хувь нь ажил эрхлээгүй байна.

Зураг 38. Ажилгүй байгаа ИДС төгсөгчид, мэргэжлийн чиглэлээр /хувь/




МБСБ-ыг аж үйлдвэрийн мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн 27.1 хувь, барилгын чиглэлээр төгсөгчдийн 16.6 хувь, тээврийн чиглэлээр төгсөгчдийн 10.5 хувь нь ажилгүй байна.

*Зураг 39. Ажилгүй байгаа МБСБ төгсөгчид, мэргэжлийн чиглэлээр /хувь/*



Ажилгүйдлийн шалтгааныг тодруулбал 20.2 хувь нь суралцдаг, 14.8 хувь нь жирэмсэн/хүүхэд асардаг, 12.8 хувь нь ажил хайгаад олдоогүй, 6.5 хувь нь цалин бага зэрэг шалтгаанууд зонхилж байна. Ажилгүйдлийн шалтгааныг сургуулиар харьцуулан үзвэл, МБСБ төгсөгчдийн 24.4 хувь нь суралцдаг, 11.7 хувь нь ажил хайгаад олдохгүй, 10.6 хувь нь жирэмсэн/хүүхэд асардаг зэрэг шалтгаантай байна. Харин ИДС төгсөгчдийн хувьд 19.8 хувь нь жирэмсэн/хүүхэд асардаг, 15.1 хувь нь суралцдаг, 14.0 хувь нь ажил хайгаад олдохгүй зэрэг шалтгаантайгаар ажилгүй байна.

Зураг 40. Ажилгүйдлийн шалтгаан /хувь/



Ажлын байрны сонголт хийхэд чухалчилдаг хүчин зүйлийг 11 үзүүлэлтээр авч үзсэн бөгөөд 5 хүртэлх баллаар үнэлүүлсэн. Ажил хайж буй төгсөгчдийн хувьд хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, ажил мэргэжлийн ирээдүй, өсөн хөгжих боломж, цалин, ажлын цаг зэргийг илүү чухалчилж үзэж байна.

Хүснэгт 7. Ажлын байр сонгоход нөлөөлдөг хүчин зүйлс

Хүчин зүйлс	ИДС төгсөгч	МБСБ төгсөгч	Бүгд
Цалин хөлс, хөдөлмөрийн үнэлэмж	4.4	4.4	4.4
Ажил амралтын цаг, уян хатан байдал	4.2	4.2	4.2
Ажлын орчин, байршил, ая тухтай байдал	4.3	4.3	4.3
Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа	4.6	4.6	4.6
Байгууллагын нэр хүнд	3.9	3.9	3.9
Ажлын чиг үүрэг, ач холбогдол	4.3	4.3	4.3
Ажлын ачаалал, дарамт	4.2	4.1	4.1
Өсөн хөгжих, суралцах, туршлагажих боломж	4.5	4.5	4.5
Карьер өсөх боломж, албан тушаал ахих боломж	4.3	4.3	4.3
Хувийн зан чанарт нийцэх байдал	4.0	4.1	4.1

Ажилд орох эсвэл бизнес эрхлэх шийдвэр гаргахад шаардлагатай сарын орлогын доод хүлээлтийн дундаж хэмжээ 2,4 сая төгрөг байна.

Ажил хайж буй төгсөгчдийн 32.4 хувь нь ажлын ярилцлагад ороод тэнцсэн боловч өөрөө тухайн ажлын байрнаас татгалзсан байна. Энэ нь цалин бага, ажиллах нөхцөл таалагдаагүй, өсөн хөгжих боломж багатайн улмаас, ажил гэр хоорондын зай зэрэг шалтгаантай байжээ.

Төгсөгчдийн ажил хайхад зарцуулж буй хичээл зүтгэлийг тодрууллаа. Нийт ажил хайж буй төгсөгчдийн 35.7 хувь нь ажил олоход хичээл гаргаагүй байна. Харин ажил олох боломжоо нэмэгдүүлэх зорилгоор 21.6 хувь нь гадаад хэлний сургалтад хамрагдах, 20.0 хувь нь боловсролын түвшин ахиулан суралцах зэрэг хэлбэрээр ажил хайх, хичээл зүтгэл гаргасан нь түгээмэл байна.

*Хүснэгт 8. Ажилд орохын тулд гаргаж буй хичээл зүтгэл, сургуулийн төрөлд эзлэх хувийн жингээр /хувь/*

Үзүүлэлт	ИДС төгсөгч	МБСБ төгсөгч	Бүгд
Хичээл зүтгэл гаргаагүй	32.2	39.1	35.7
Гадаад хэлний сургалт, дамжаанд хамрагдах, шалгалтад бэлдэх	29.7	13.4	21.6
Боловсролын түвшнээ ахиулан суралцах	19.8	20.2	20.0
Мэргэжлийн сургалтад хамрагдах	14.1	14.5	14.3
Компьютер, программын сургалтад хамрагдах	16.6	7.6	12.1
Дадлага хийх, сайн дурын болоод олон нийтийн ажилд оролцох	7.7	9.9	8.8
Ажлын байрны ярилцлагад бэлтгэх	9.8	5.6	7.7
Гадаад төрхдөө анхаарах	4.3	4.0	4.2
Бусад	4.1	1.9	3.0

Ажил хайж буй төгсөгчдийн ажилд ороход тулгардаг бэрхшээлийг тодруулахад 16.5 хувь нь цалин хөлс бага, 14.1 хувь нь ажлын цаг уян хатан бус, 13.3 хувь нь ажлын туршлага дутах, 12.7 хувь нь ажлын байрны мэдээллийн хомсдол, 12.7 хувь нь мэргэжилд тохирох ажил олдохгүй зэрэг хүчин зүйлийг түлхүү дурджээ.


Хүснэгт 9. Ажил хайх явцад гардаг хүндрэл бэрхшээл /хувь/

Үзүүлэлт	ИДС төгсөгч	МБСБ төгсөгч	Бүгд
Санал болгож буй цалин хөлс хэтэрхий бага	16.0	17.1	16.5
Бусад	13.0	16.0	14.5
Ажлын цаг хэт урт эсвэл уян хатан бус	12.9	15.3	14.1
Туршлага дутах, эсвэл ажил олгогчийн шаардаж буй ажлын туршлагад нийцэхгүй байх	16.3	10.3	13.3
Ажлын байрны мэдээлэл хомс, эсвэл хаанаас мэдээлэл олохоо мэддэггүй	11.6	13.8	12.7
Ажил олгогчид ажлын байранд нас, хүйс, гадаад дүр төрх, биеийн хөгжил харгалзан сонгон шалгаруулж авдаг	6.6	7.5	7.0
Ажлын байрны орчин, байршил зэрэг нь ая тухтай, эрүүл, аюулгүй биш	6.7	5.1	5.9
Мэргэжилд тохирох ажил олдохгүй байх	4.8	5.1	4.9
Авлига, танил тал шаардлагатай болдог	5.0	3.9	4.5
Суралцах хугацаандаа эзэмшсэн мэдлэг, ур чадвар ажил олгогчийн шаардлагад нийцдэггүй	4.7	2.9	3.8
Өөрийн эзэмшсэн мэдлэг, боловсрол, ур чадварт итгэлгүй байх	2.5	3.1	2.8
Бүгд	100.0	100.0	100.0

Нийт төгсөгчдийн 14.2 хувь нь ажиллах хүчнээс гадуур буюу эдийн засгийн идэвхгүй төлөвт байна. Тэдний 7.0 хувь нь ИДС төгсөгч, 12.9 хувь нь МБСБ төгсөгч байна. Харин байршлын хувьд 60.2 хувь нь Улаанбаатарт, 39.8 хувь нь хөдөө, орон нутагт амьдарч байна. Ажиллах хүчнээс гадуур байгаа төгсөгчдийн 32.5 хувь нь эрэгтэй, 67.5 хувь нь эмэгтэй байгаа бол ИДС төгсөгчдийн 57.7 хувь нь, МБСБ төгсөгчдийн 81.8 хувь нь эмэгтэй байна.

Сүүлийн 30 хоногт цалин хөлстэй ажил олох болон бизнес эрхлэх гэж оролдоогүй ажиллах хүчнээс гадуур байгаа төгсөгчдийн 42.5 хувь нь гэр бүлийн шалтгаанаар, 21.5 хувь нь суралцаж байсан, сургалтад хамрагдаж байгаа, 7.2 хувь нь өвчтэй хөгжлийн бэрхшээлтэй зэрэг түлхүү шалтгаантай байна. Үүнийг сургуулийн төрлөөр нь авч үзвэл ИДС төгсөгчдийн 48.8 хувь нь гэр бүлийн шалтгаанаар, 17.0 хувь нь суралцаж байсан, сургалтад хамрагдаж байгаа, 6.2 хувь нь өвчтэй хөгжлийн бэрхшээлтэй, МБСБ төгсөгчдийн 37.5 хувь нь гэр бүлийн шалтгаанаар, 24.2 хувь нь суралцаж байсан, сургалтад хамрагдаж байгаа, зэрэг шалтгаанууд зонхилж байна.


**Зураг 41. Сүүлийн 30 хоногт ажил олох, бизнес эрхлэх гэж оролдоогүй шалтгаан /хувь/**



Ажилгүй болон ажиллах хүчнээс гадуур байгаа төгсөгчдийн орлогын гол эх үүсвэрийн 79.6 хувийг нь эцэг, эх, нөхөр, эхнэр, хүүхэд, ах дүүгийн цалин орлого, 8.1 хувь нь хадгаламжийн хүүгийн орлогоор, хувийг нь, 4.1 хувийг нь нийгмийн халамжийн мөнгөн тэтгэмж, амьжиргаанд дэмжлэг үзүүлэх хөнгөлөлт, тусламж эзэлж байна.

## 5.2 Ажлын цаг, давхар хөдөлмөр эрхлэх байдал

**Зураг 42. Хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлаа өөрчлөх хүсэл, сургуулийн төрлөөр /хувь/**



Сургуулийн төрлөөр авч үзвэл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлаа өөрчлөх хүсэл ИДС төгсөгчдийн 39.9 хувь, МБСБ төгсөгчдийн 37.6 хувь байна. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн дийлэнх нь одоогийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлдөө харьцангуй сэтгэл ханамжтай байна

Одоогийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлаа өөрчлөхийг хүссэн хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн хувьд илүү цалинтай ажилд орох нь хамгийн гол шалтгаан болж байгаа бөгөөд ИДС төгсөгчдийн 43.4 хувь нь илүү цалинтай ажилд орох, 15.8 хувь нь ур чадвараа сайжруулах, 12.0 хувь нь ажлын бусад нөхцөл байдлыг сайжруулах, 7.5 хувь нь тогтвортой баталгаатай ажлын байртай болох зэрэг шалтгаанууд зонхилж байна.

**Зураг 43. ИДС төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлөө өөрчлөх шалтгаан /хувь/**



МБСБ төгсөгчдийн хувьд хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлаа өөрчлөхийг хүсэх гол шалтгаан нь илүү цалинтай ажилд орох (31.3%) байгаа боловч тогтвортой, баталгаатай ажлын байртай болох (18.5%) шалтгаан харьцангуй өндөр байна. Ур чадвараа сайжруулах (13.0%), ажлын бусад нөхцөл байдлыг сайжруулах (10.8%) зэрэг хүчин зүйлс тодорхой хувийг эзэлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлаа өөрчлөхийг хүсэх гол шалтгаан нь илүү өндөр цалин, ур чадвараа хөгжүүлэх боломж болон тогтвортой ажлын байртай холбоотой байна. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн чанарыг сайжруулах хүрээнд өрсөлдөхүйц цалин хөлс, ур чадвар хөгжүүлэх боломж, тогтвортой ажлын байрны нөхцөлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

**Зураг 44. МБСБ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлөө өөрчлөх шалтгаан /хувь/**



Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 74.8 хувь нь сүүлийн 30 хоногт ажлаа солих эсвэл давхар хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайгаагүй бол давхар хөдөлмөр эрхлэх зорилгоор 13.0 хувь нь, ажлаа солих зорилгоор 12.2 хувь нь ажил хайж байна. Энэ нь төгсөгчдийн дийлэнх нь одоогийн ажлын байрандаа тогтвортой ажиллаж байгаа боловч тодорхой хувь нь орлого нэмэгдүүлэх болон тохиромжтой ажлын байр хайж байна.

Ажлаа солихоор төлөвлөж буй төгсөгчдөөс гол шалтгааныг тодруулахад 33.6 хувь нь ажлын хөлс бага, илүү өндөр орлого олох ажил хийх хүсэлтэй байна. Харин 16.8 хувь нь ажлын цаг урт, уян хатан бус, ачаалал их, 9.4 хувь нь албан тушаал ахих, хөгжих боломж бага, 7.9 хувь нь мэргэжил, боловсрол, ур чадварт илүү тохирсон ажил хийх хүсэлтэй байна. Мөн 7.2 хувь нь хамт олны уур амьсгал, удирдлагын хандлага, 5.9 хувь нь шинэ сорилт, шинэ орчинд ажиллах хүсэл зэрэг шалтгааныг дурдсан байна.

Ажлаа солихоор төлөвлөж буй төгсөгчдийн хувьд голлон нөлөөлж буй хүчин зүйл нь цалин хөлсний хэмжээ, ажлын цагийн нөхцөл болон карьерын өсөлт, хөгжлийн боломжтой холбоотой байна. Ялангуяа илүү өндөр орлого олох хүсэлтэй төгсөгчдийн хувь хамгийн өндөр байгаа нь ажлын байрны эдийн засгийн нөхцөл чухал нөлөөтэй байна.

Ажлаа солихоор төлөвлөж буй төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр авч үзвэл ИДС төгсөгчдийн хувьд бизнес, удирдахуй, хууль, эрх зүйн мэргэжлийн чиглэлээр төгссөн төгсөгчид дийлэнх хувийг эзэлж байна.


**Зураг 45. Ажлаа солихоор төлөвлөж буй ИДС төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийн чиглэл /хувь/**



МБСБ төгсөгчдийн аж үйлдвэр болон барилгын мэргэжлийн чиглэлээр төгссөн төгсөгчид дийлэнх хувийг эзэлж байна.

Давхар хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдөөс давхар хөдөлмөр эрхлэх болсон шалтгааныг тодруулахад төгсөгчдийн 28.1 хувь нь хуримтлал үүсгэх зорилготой, 23.7 хувь нь үндсэн ажлын цалин, орлого хангалтгүй, 18.8 хувь нь өр зээл, санхүүгийн дарамтаас гарах зорилгоор давхар ажил эрхэлж байна. Сургуулийн төрлөөр авч үзвэл давхар хөдөлмөр эрхлэх гол шалтгаан нь аль алинд нь санхүүгийн хэрэгцээтэй холбоотой байна. ИДС төгсөгчдийн 31.9 хувь нь үндсэн ажлын цалин, орлого хангалтгүй гэж үзсэн нь МБСБ төгсөгчдөөс (23.7%) өндөр байна.

Зураг 46. Давхар ажил хийж буй шалтгаан, сургуулийн төрлөөр /хувь/




Ажил хайх явцад тулгарч буй хамгийн их бэрхшээлийг тодруулахад 17.6 хувь нь ажлын байрны мэдээллийн хомсдол, хаанаас мэдээлэл авах талаар мэдэхгүй, 16.8 хувь нь ажлын цаг урт, уян хатан бус, 14.6 хувь нь ажлын туршлага дутмаг, ажил олгогчийн шаардлагад нийцэхгүй байх зэрэг шалтгаанууд байна.

Сургуулийн төрлөөр авч үзвэл МБСБ төгсөгчдийн хувьд ажлын байрны мэдээллийн хомсдол (19.9%) илүү бэрхшээл болж байгаа бол ИДС төгсөгчдийн хувьд ажлын туршлага дутмаг, шаардлага нийцэхгүй байх (15.7%) нь харьцангуй өндөр байна. Энэ нь төгсөгчид ажил хайх явцад мэдээллийн хүртээмж болон ажлын туршлагатай холбоотой бэрхшээлүүд нийтлэг тулгарч байна.



**БҮЛЭГ 6. ӨМНӨХ ҮЕИЙН  
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**



## 6.1 Суралцах хугацааны хөдөлмөр эрхлэлт

Төгсөгчдийн 69.4 хувь нь суралцаж байх хугацаандаа цалин, хөлстэй хөдөлмөр эрхэлж байсан бол 30.9 хувь нь хөдөлмөр эрхлээгүй байна. Сургуулийн төрлөөр авч үзвэл ИДС төгсөгчдийн 75.7 хувь нь, МБСБ төгсөгчдийн 59.7 хувь нь суралцах хугацаандаа ажил эрхэлж байсан нь ИДС төгсөгчид харьцангуй өндөр оролцоотой байгааг харуулж байна.

Ажил эрхэлж байсан төгсөгчдийн хувьд ихэнх нь хичээлийн хажуугаар хагас цагийн ажил (55.2%) болон хичээлийн амралтаар ажиллах (36.7%) хэлбэрээр ажилласан байна. Мөн 20.0 хувь нь суралцах хугацаандаа бүтэн цагийн ажил, 7.9 хувь нь цалин хөлстэй дадлага хийж байсан байна. Харин суралцах хугацаандаа ажил эрхлээгүй төгсөгчдийн 95.6 хувь нь огт ажил хийж байгаагүй, 4.4 хувь нь цалин хөлсгүй хөдөлмөр эрхэлж байсан байна.

Төгсөгчдийн дийлэнх нь суралцах хугацаандаа хөдөлмөр эрхэлж, ажлын тодорхой туршлага хуримтлуулсан бөгөөд энэ нь хөдөлмөрийн зах зээлд бэлтгэгдэхэд эерэг нөлөө үзүүлэх боломжтойг харуулж байна.

Суралцах хугацаандаа ажил эрхэлсэн төгсөгчдийн 74.2 хувь нь хэрэглээний мөнгөө өөрөө олох зорилгоор ажил хийсэн байна. Мөн 26.5 хувь нь сургалтын төлбөрөө төлөх, 12.4 хувь нь орлого олж хуримтлалтай болохыг хүссэн, 12.2 хувь нь ирээдүйн мэргэжлийн чиглэлээр туршлага хуримтлуулах зэрэг шалтгаанууд нэлээд хувийг эзэлж байна. Төгсөгчид суралцах хугацаандаа ажил эрхлэх гол шалтгаан нь санхүүгийн хэрэгцээг хангахын зэрэгцээ тодорхой хэмжээнд туршлага хуримтлуулах, ур чадвараа хөгжүүлэх зорилготой байжээ.

**Зураг 47. Төгсөгчдийн суралцах хугацаандаа хөдөлмөр эрхлэх гол шалтгаан /хувь/**




Суралцах хугацаандаа ажил эрхэлсэн төгсөгчдийн хувьд эрхэлж байсан ажил нь эзэмшсэн мэргэжилтэй холбоотой байсан эсэхийг авч үзэхэд ИДС төгсөгчдийн 49.6 хувь нь мэргэжилтэйгээ холбоотой ажил хийж байсан бол 50.4 хувь нь холбоогүй ажил эрхэлсэн байна. Харин МБСБ төгсөгчдийн 56.2 хувь нь мэргэжилтэйгээ холбоотой ажил эрхэлж байсан бол 43.8 хувь холбоогүй ажил хийсэн байна. МБСБ төгсөгчид суралцах хугацаандаа мэргэжилтэйгээ илүү тохирсон ажил эрхлэх хандлага ИДС төгсөгчдөөс өндөр байна.


Суралцах хугацаандаа ажил эрхэлснээр төгсөгчид хамгийн ихээр буюу 56.8 хувь нь харилцааны чадвар, 36.0 хувь нь цагийн менежмент, ажлаа төлөвлөх чадвар эзэмшсэн байна. Мөн 24.6 хувь нь ажлын сахилга бат, хариуцлага, 12.8 хувь нь асуудлыг бие даан шийдвэрлэх, хурдан сэтгэх чадвар тодорхой хэмжээгээр хөгжсөн байна.

Үүнээс гадна 10.9 хувь нь мэргэжлийн тусгай ур чадвар, 9.9 хувь нь удирдан зохион байгуулах чадвар, 8.6 хувь нь танилын хүрээ тэлэх зэрэг ур чадварууд нэмэгдсэн байна. Суралцах хугацаандаа ажил эрхлэх нь төгсөгчдөд харилцаа, цагийн менежмент, хариуцлага зэрэг хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай суурь ур чадварыг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.

Зураг 48. Төгсөгчдийн суралцах хугацаанд ажил эрхэлснээр эзэмшсэн ур чадвар /хувь/



Зураг 49. Суралцах хугацаанд эзэмшсэн ур чадваруудын ажлын байранд ашиглагдаж буй байдал, сургуулийн төрлөөр /хувь/




Төгсөгчдийн 76.5 хувь нь суралцах хугацаандаа эзэмшсэн ихэнх ур чадварууд нь одоогийн ажил үүргээ гүйцэтгэхэд хэрэг болж байна гэж үзжээ. Харин 16.9 хувь нь зарим ур чадварууд ашиглагддаг, 4.3 хувь нь бараг ашиглагддаггүй гэж хариулсан бол 2.2 хувь нь тодорхойлох боломжгүй гэж үзсэн байна. Сургуулийн төрлөөр авч үзвэл ИДС төгсөгчдийн 78.1 хувь нь, МБСБ төгсөгчдийн 73.4 хувь нь эзэмшсэн ур чадварууд нь одоогийн ажилд хэрэг болж байгааг илэрхийлсэн байна. Суралцах хугацаандаа эзэмшсэн ур чадварууд нь төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн бодит хэрэгцээнд нийцэж, ажлын байранд ашиглагдах боломж өндөр байна.

Төгсөгчдийн 69.4 хувь нь суралцах хугацаандаа цалин, хөлстэй хөдөлмөр эрхэлж байсан бөгөөд ихэнх нь хичээлийн хажуугаар хагас цагийн ажил болон амралтын үеэр ажиллах хэлбэрээр хөдөлмөр эрхэлсэн байна. Төгсөгчид ажил эрхлэх гол шалтгаан нь хэрэглээний мөнгөө өөрөө олох, сургалтын төлбөрөө төлөх, орлого хуримтлал бий болгох зэрэг санхүүгийн хэрэгцээтэй холбон тайлбарласан байна. Мөн тодорхой хэсэг нь мэргэжлийн туршлага хуримтлуулах, ур чадвараа хөгжүүлэх зорилгоор ажил хийжээ.

Суралцах хугацаандаа ажил эрхэлснээр төгсөгчдөд харилцааны чадвар, цагийн менежмент, ажлын сахилга бат, асуудлыг бие даан шийдвэрлэх зэрэг хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай ур чадварууд түлхүү хөгжсөн байна. Эдгээр ур чадваруудын хувьд төгсөгчдийн ихэнх буюу 76.5 хувь нь одоогийн ажил үүргээ гүйцэтгэхэд хэрэг болж байна гэж үнэлсэн нь суралцах хугацаанд ажил эрхлэх нь бодит ажлын туршлага хуримтлуулах, хөдөлмөрийн зах зээлд дасан зохицоход чухал ач холбогдолтойг харуулж байна. Суралцах хугацаанд ажил эрхлэх нь төгсөгчдийн санхүүгийн хэрэгцээг хангахаас гадна ур чадвар хөгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэгдэхэд эерэг нөлөө үзүүлж байгааг судалгааны дүн харуулж байна.

## 6.2 Суралцах хугацаанд хийсэн дадлага


Зураг 50. Төгсөгчдийн суралцах хугацаанд мэргэжлийн дадлага хийсэн байдал, сургуулийн төрлөөр /хувь/




Судалгаанд хамрагдсан нийт төгсөгчдийн 90.3 хувь нь суралцах хугацаандаа мэргэжлийн дадлага хийсэн байна. Сургуулийн төрлөөр авч үзвэл ИДС төгсөгчдийн 89.7 хувь нь, МБСБ төгсөгчдийн 91.3 хувь нь дадлага хийсэн бөгөөд ихэнх төгсөгчид суралцах хугацаандаа мэргэжлийн практик туршлага эзэмшсэн байна.

Нийт төгсөгчдийн 65.2 хувь нь дадлага хийх хугацаанд олж авсан мэдлэг, ур чадвар нь ажлын байранд ихэнхдээ хэрэг болж байна гэж хариулсан байна. Мөн 20.8 хувь нь зарим ур чадвар ашиглагддаг, 10.5 хувь нь бараг ашигладаггүй гэж үзсэн бол 3.6 хувь нь тодорхойлох боломжгүй гэж хариулжээ. Дадлагын хугацаанд олж авсан мэдлэг, ур чадвар нь төгсөгчдийн дийлэнх хэсгийн хувьд ажлын байранд тодорхой хэмжээнд хэрэг болж байна.

*Зураг 51. Төгсөгчдийн дадлага хийх хугацаанд олж авсан мэдлэг, ур чадвар ажлын байранд ашиглагдаж буй байдал /хувь/*



*Зураг 52. Дадлагын хугацаа практик ур чадвар эзэмшихэд хангалттай байсан эсэх, сургуулийн төрлөөр /хувь/*




Харин ИДС төгсөгчдийн 31.8 хувь нь, МБСБ төгсөгчдийн 16.0 хувь дадлагын хугацаа хангалтгүй байсан гэж үзжээ.

ИДС төгсөгчдийн 29.4 хувь нь, МБСБ төгсөгчдийн 53.3 хувь нь дадлага хийх хугацаандаа цалин авч байсан. Харин ИДС төгсөгчдийн 70.6 хувь, МБСБ төгсөгчдийн 46.7 хувь нь дадлагын хугацаанд цалин аваагүй гэж хариулжээ.

МБСБ төгсөгчдийн дунд дадлагын хугацаанд цалин авсан хувь харьцангуй өндөр байгаа нь мэргэжлийн боловсролын сургалт ажлын байр, үйлдвэрлэлтэй илүү уялдсан байдгийг илтгэж байна. Харин ИДС төгсөгчдийн дунд дадлагын хугацаанд цалин аваагүй хувь өндөр байна.

**Зураг 53. Төгсөгчдийн дадлага хийсэн байгууллагаасаа үндсэн ажилтнаар үлдэх авсан санал байдал /хувь/**




Нийт төгсөгчдийн 56.8 хувь нь дадлага хийж байсан байгууллагаасаа үндсэн ажилтан болж үлдэх санал авч байсан гэж хариулсан бол 43.2 хувь нь ийм санал аваагүй байна. Төгсөгчдийн талаас илүү хувь нь дадлагын хугацаанд байгууллагатай шууд ажиллаж, тухайн байгууллагаас цаашид ажиллах санал авч байсан байна.

Суралцах хугацааны дадлага нь төгсөгчдийн хувьд зөвхөн практик мэдлэг, ур чадвар эзэмшихээс гадна ирээдүйд ажилд орох боломжийг бий болгоход тодорхой үүрэг гүйцэтгэж байна. Иймд сургалтын байгууллагууд дадлагын хөтөлбөрийг байгууллагууд илүү уялдуулан зохион байгуулах нь төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой юм.

Нийт төгсөгчдийн 46.1 хувь нь тухайн дадлага хийсэн байгууллагын талаар (сургууль, тэнхим болон сургуулийн дэргэдэх зуучлалын нэгжээс) мэдээлэл авч олсон байна. Мөн 21.5 хувь нь багш нар болон дээд үеийн төгсөгчдөөс мэдээлэл авч, 17.5 хувь нь гэр бүл, хамаатан садан, найз нөхдөөсөө дадлагын байгууллагынхаа мэдээллийг авсан байна.

**Зураг 54. Төгсөгчдийн дадлага хийсэн байгууллагыг олсон эх үүсвэр /хувь/**



Судалгааны дүнгээс харахад төгсөгчдийн суралцах хугацаандаа хийсэн мэргэжлийн дадлага нь хөдөлмөрийн зах зээлд шилжин орох боломжид чухал нөлөө үзүүлж байна. Төгсөгчдийн дийлэнх нь дадлагаар олж авсан мэдлэг, ур чадвар нь ажлын байранд хэрэг болж байгааг онцолсон бөгөөд зарим төгсөгчид дадлага хийсэн байгууллагаасаа үндсэн ажилтнаар ажиллах санал авсан байна. Дадлага нь төгсөгчдийн ажлын байрны туршлага хуримтлуулах, ажил олгогчтой шууд холбогдох боломжийг бүрдүүлж, төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээлд шилжин ороход дэмжлэг үзүүлэх чухал хүчин зүйл болж байна.

### **6.3 Одоогийн үндсэн ажлаас өмнөх хөдөлмөр эрхлэлт**


Нийт төгсөгчдийн 63.0 хувь нь сургуулиа төгссөний дараа одоогийн хийж буй нэг ажлаа тасралтгүй хийж байна. Сургуулийн төрлөөр авч үзвэл, ИДС төгсөгчдийн 68.8 хувь, МБСБ төгсөгчдийн 54.1 хувь нь одоогийн ажлаа хийж эхэлсэн бөгөөд ажлын байрны тогтвортой байдал харьцангуй өндөр байна.

Мөн одоогийн ажлаасаа өмнө өөр хэд хэдэн ажил хийж байсан төгсөгчид нийт төгсөгчдийн 19.9 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь ИДС төгсөгчдийн 18.9 хувь, МБСБ төгсөгчдийн 21.5 хувь байна. Харин одоогоор ажилгүй боловч төгссөнөөс хойш нэг ажил хийж байсан төгсөгчид 4.9 хувь, хэд хэдэн ажил хийж байсан төгсөгчид 3.5 хувь байна.

Түүнчлэн төгссөнөөс хойш огт ажил хийж байгаагүй төгсөгчид нийт төгсөгчдийн 8.7 хувийг эзэлж байгаа бөгөөд үүнийг сургуулийн төрлөөр авч үзвэл ИДС төгсөгчдийн 6.1 хувь, МБСБ төгсөгчдийн 12.7 хувь байна.

Төгсөгчдийн дийлэнх нь сургуулиа төгссөний дараа хөдөлмөрийн зах зээлд орж, одоогийн хийж буй ажлаа тогтвортой үргэлжлүүлэн хийж байна. Ялангуяа ИДС төгсөгчдийн хувьд нэг ажлаа тасралтгүй хийж байгаа хувь өндөр байгаа бол МБСБ төгсөгчдийн дунд ажлын байр солих болон төгсөөд ажил хийгээгүй төгсөгчдийн хувь харьцангуй өндөр байна.

**Зураг 55. Сургуулиа төгссөний дараах хөдөлмөр эрхлэлтийн байдал, сургуулийн төрлөөр /хувь/**



Сургуулиа төгссөнөөс хойш одоогийн ажлаасаа өмнө өөр ажил хийж байсан төгсөгчдийн 45.5 хувь нь хоёр ажил хийсэн гэж хариулсан нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Мөн 24.1 хувь нь гурван ажил, 14.2 хувь нь нэг ажил хийсэн байна. Харин 8.2 хувь нь дөрвөн ажил, 4.4 хувь нь таван ажил, 1.4 хувь нь зургаан ажил хийсэн байна. Энэ нь сургуулиа төгссөний дараа одоогийн ажлаасаа өмнө өөр ажил хийж байсан төгсөгчдийн дийлэнх нь хоёр ба түүнээс дээш ажил хийсэн байгаа нь хөдөлмөрийн зах зээлд шилжих явцад ажлын байр солих хөдөлгөөн тодорхой хэмжээнд байна.

Төгссөний дараа одоогийн хийж буй үндсэн ажлаас өмнө ажил эрхэлж байсан төгсөгчдийн тухайн үеийн ажлын байрны статусыг тодруулж үзэхэд 84.2 хувь нь цалин хөлстэй ажиллагч байсан нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Мөн 10.5 хувь нь ажил олгогч, 3.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байна.


Төгсөгчдийн одоогийн үндсэн ажлаас өмнөх хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзэхэд дийлэнх нь цалин хөлстэй ажил эрхэлж байсан байна.

Зураг 56. Одоогийн ажлаас өмнөх хөдөлмөр эрхлэлтийн статус /хувь/



Сургуулиа төгссөнөөс хойш одоогийн хийж буй үндсэн ажлаас өмнө эрхэлж байсан ажлын байрны хэлбэрийг авч үзэхэд 77.9 хувь нь байнгын ажлын байртай, 18.6 хувь нь түр ажлын байртай, 3.5 хувь нь тохиолдлын ажил эрхэлж байсан байна.

Зураг 57. Одоогийн ажлаас өмнөх эрхэлж байсан ажлын байрны хэлбэр /хувь/



Сургуулиа төгссөний дараа одоогийн үндсэн ажлаас өмнө ажиллаж байсан байгууллага, ажлын байрнаас гарахад нөлөөлсөн хүчин зүйлсийг сургуулийн төрлөөр авч үзэхэд цалин хөлсний хэмжээ хамгийн өндөр хувийг эзэлж байна. Тухайлбал, ИДС төгсөгчдийн 31.1 хувь нь, МБСБ төгсөгчдийн 22.2 хувь нь цалин хөлс бага байсан шалтгааныг дурдсан байна. ИДС төгсөгчдийн 15.2 хувь, МБСБ төгсөгчдийн 21.4 хувь нь түр хугацааны ажлын байр байсан гэж хариулсан байна.


Төгсөгчдийн өмнөх ажлын байрнаас гарахад нөлөөлсөн хүчин зүйлсийг авч үзэхэд цалин хөлсний хэмжээ, ажлын байрны тогтворгүй байдал болон хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой шалтгаанууд голлон нөлөөлж байна. Мөн сургуулийн төрлөөр авч үзэхэд ИДС төгсөгчдийн хувьд цалин хөлсний асуудал илүү нөлөөлсөн бол МБСБ төгсөгчдийн хувьд түр хугацааны ажлын байр байсан нь ажлын байрнаас гарахад харьцангуй илүү нөлөөлсөн байна.

*Зураг 58. Төгсөгчдийн өмнөх ажлын байрнаас гарахад нөлөөлсөн хүчин зүйлс, сургуулийн төрлөөр /хувь/*




Судалгааны дүнгээс харахад төгсөгчдийн тодорхой хэсэг нь сургуулиа төгссөний дараа одоогийн үндсэн ажлаа эрхлэхээс өмнө хөдөлмөр эрхэлж байсан байна. Тэдгээр төгсөгчдийн дийлэнх нь цалин хөлстэй ажил эрхэлж байсан бөгөөд ихэнх нь байнгын болон тодорхой хугацаатай ажлын байранд ажиллаж байжээ. Мөн төгсөгчдийн олонх нь одоогийн эрхэлж буй ажлаасаа өмнө хоёр ба түүнээс дээш ажил хийж байсан нь хөдөлмөрийн зах зээлд шилжих явцад тодорхой хэмжээнд ажлын байр солих хөдөлгөөн байгааг харуулж байна.

Түүнчлэн өмнөх ажлын байрнаас гарахад цалин хөлсний хэмжээ, ажлын байрны тогтворгүй байдал, ажлын нөхцөл болон хувь хүний хөгжлийн хэрэгцээ зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна. Иймээс төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд ажлын байрны нөхцөл, цалин урамшууллын бодлого чухал нөлөөтэй болохыг энэхүү судалгааны үр дүн харуулж байна.



## БҮЛЭГ 7. ЦААШДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



## 7.1 Ирээдүй төлөвлөгөө, дахин суралцах байдал

Нийт төгсөгчдөөс ирэх нэг жилийн төлөвлөгөө, дахин суралцах байдлыг тодруулсан. Төгсөгчдийн 33.5 хувь нь одоо хийж буй ажлаа үргэлжлүүлэн хийнэ гэсэн бол 9.3 хувь нь давхар хөдөлмөр эрхлэх, орлогын нэмэлт эх үүсвэртэй болох, 9.1 хувь нь ажлаа өөрчлөх, 8.8 хувь нь гадаад, дотоодын сургуульд элсэн суралцах, 8.7 хувь нь хувиараа бизнес эрхлэх, 8.2 хувь нь ажилд орох зэрэг төлөвлөгөөтэй байгаагаа илэрхийлсэн.

Төгсөгчдийн ихэнх нь ойрын нэг жилийн хугацаанд одоо хийж буй ажлаа үргэлжлүүлэн хийх төлөвлөгөөтэй байгаа нь хөдөлмөр эрхлэлтийн тодорхой түвшний тогтвортой байдлыг илтгэж байна. Мөн зарим төгсөгчид орлогоо нэмэгдүүлэх, ажлаа өөрчлөх, цаашид суралцах, хувиараа бизнес эрхлэх зэрэг чиглэлд төлөвлөгөөтэй байгаа нь тэд өөрсдийн мэргэжлийн болон эдийн засгийн боломжийг сайжруулах сонирхолтой байна. Харин тодорхой төлөвлөөгүй төгсөгчдийн хувь харьцангуй бага байгаа нь ихэнх төгсөгчид цаашдын хөдөлмөр эрхлэлт, хөгжлийн талаар тодорхой чиг баримжаатай байна.


Зураг 59. Төгсөгчдийн ойрын нэг жилийн төлөвлөгөө /хувь/



Суралцах төлөвлөгөөтэй байгаа ИДС төгсөгчдийн хувьд 47.7 хувь нь гадаадын сургуульд суралцах, 44.7 хувь нь мэргэжлээ дээшлүүлэн ахисан түвшинд суралцах сонирхол харьцангуй өндөр байгаа нь олон улсын боловсрол эзэмших, мэргэжлийн мэдлэгээ гүнзгийрүүлэх хандлага давамгайл байгааг харуулж байна. Харин МБСБ төгсөгчдийн дунд 40.8 хувь нь дотоодын сургуульд суралцах, 35.4 хувь нь ахисан түвшинд суралцах төлөвлөгөөтэй байна.

Цаашид суралцах төлөвлөгөөтэй байгаа төгсөгчдийн шалтгааныг тодруулахад төгсөгчдийн дийлэнх буюу 59.3 хувь нь өөрийгөө хөгжүүлэх, шинэ мэдлэг ур чадвар, эзэмших зорилгоор дахин суралцах, 12.4 хувь нь цалин хөлс болон хөдөлмөрийн үнэлэмжээ нэмэгдүүлэх, 10.8 хувь нь шинэ ажилд орох эсвэл илүү ажлын байр олон, эрэлттэй мэргэжил эзэмших, 6.7 хувь нь Өмнөх мэргэжил өөрийн хүссэн мэргэжил биш байсан эсвэл сонирхолгүй болсон, 5.2 хувь нь Ажил олгогчийн шаардлагаар эсвэл тушаал дэвших зорилгоор, 2.4 хувь нь Бусад, 2.1 хувь нь Нэмэлт орлогын эх үүсвэртэй болох, 1.1 хувь нь Эрүүл мэнд, гэр бүл гэх мэт хувийн шалтгаанаар

*Зураг 60. Цаашид суралцах төлөвлөгөөтэй байгаа төгсөгчдийн шалтгаан /хувь/*



Цаашид сурахаар төлөвлөж буй төгсөгчдийн 38.3 хувь нь өмнө нь эзэмшсэн мэргэжилтэйгээ яг адил, 25.3 хувь нь төстэй, 16.3 хувь нь бага зэрэг төстэй, 20.1 хувь нь өмнөх мэргэжлээсээ огт өөр чиглэлээр суралцахаар төлөвлөж байна.

Өөр мэргэжлээр суралцахаар төлөвлөж буй төгсөгчдөөс 41.6 хувь нь давхар мэргэжил эзэмших, 19.4 хувь нь боловсролын түвшин зэрэг ахиулах, 19.4 өмнө эзэмшсэн мэргэжил хувийн сонирхол, зан төлөвт тохирдоггүй, 13.1 суурь мэргэжлээрээ ажилд ороход хүндрэлтэй гэж үзсэн байна.

Зураг 61. Өмнө эзэмшсэн мэргэжлээс өөр чиглэлээр суралцах гол шалтгаан /хувь/





# ДҮГНЭЛТ



Энэхүү судалгаагаар 2023–2024 оны хичээлийн жилд төгссөн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээлд шилжих үйл явц, мэргэжил-ур чадварын нийцэл болон тулгамдаж буй асуудлуудыг тодорхойллоо.

Судалгааны үр дүнгээс харахад нийт төгсөгчдийн 81.3 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа нь хөдөлмөр эрхлэлтийн түвшин харьцангуй өндөр байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч хөдөлмөр эрхлэлтийн чанарын асуудал зонхилж байна. Тухайлбал, цалин хөлсний түвшин хангалтгүй, ажлын байрны тогтвортой байдал сул, ажлын ачаалал их зэрэг хүчин зүйлс нь төгсөгчдийн ажлын байрны сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлж байна.

Их, дээд сургуулийн төгсөгчдийн хувьд инженерчлэл, эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуйн чиглэлүүдэд мэргэжлээрээ ажиллах хувь өндөр байна. Харин байгалийн шинжлэх ухаан, нийгмийн шинжлэх ухаан, урлаг, хүмүүнлэгийн чиглэлүүдэд мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэлт өндөр байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хувьд мэргэжлээрээ ажиллах хувь дунд түвшинд байна. Зарим чиглэлд (боловсрол, батлан хамгаалах, санхүү, худалдаа) мэргэжлийн нийцэл өндөр байгаа хэдий ч мэдээлэл технологи, үйлчилгээ зэрэг салбарт мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэлт өндөр байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хувьд албан бус хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн гэрээ байгуулахгүйгээр ажиллах тохиолдол байдал өндөр байна.

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн чанарт цалин хөлсний хэмжээ, ажлын байрны нөхцөл, карьерын өсөлтийн боломж голлон нөлөөлж байгаа бөгөөд тодорхой хувь нь илүү өндөр орлого олох, ажлын нөхцөлөө сайжруулах зорилгоор ажлаа солих, давхар ажил эрхлэх хандлагатай байна.

Нийт төгсөгчдийн тодорхой хэсэг нь ажиллах хүчнээс гадуур буюу эдийн засгийн идэвхгүй бүлэгт багтаж байгаа бөгөөд үүнд суралцах, гэр бүлийн үүрэг, хүүхэд асрах зэрэг хувийн шалтгаанууд давамгайлж байна.

Суралцах хугацаандаа хөдөлмөр эрхэлсэн туршлага нь төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээлд дасан зохицох чадварыг нэмэгдүүлж, харилцаа, цагийн менежмент, асуудал шийдвэрлэх зэрэг ур чадварыг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн байна.



САНАЛ, ЗӨВЛӨМЖ



- Мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэлт өндөртэй чиглэлүүдэд элсэлтийн бодлогыг оновчтой болгох шаардлагатай байна.
- Гадаад хэл, мэдээллийн технологи, баримт бичиг боловсруулах ур чадварыг сургалтын агуулгад түлхүү тусгах нь ажил олгогчоос ажлын байранд тавигдах шаардлагыг хангах боломжтой, энэ нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх тодорхой нөлөөллийг үзүүлэхээр байна.
- Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн дунд дутагдаж буй багаар ажиллах, харилцааны, бие даан ажиллах, шийдвэр гаргах зэрэг ерөнхий (зөөлөн) ур чадваруудыг сургалтын хөтөлбөрт системтэй тусган, үе шаттайгаар зайлшгүй эзэмшүүлэх шаардлагатай.
- Хөдөлмөрийн зах зээлд ур чадварт суурилсан цалингийн тогтолцоог хөгжүүлэх, өндөр ур чадвар шаардсан салбаруудад ажиллах төгсөгчдийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай.
- Хөдөлмөрийн гэрээгүй болон нийгмийн даатгалд хамрагдаагүй хөдөлмөр эрхлэлтийг бууруулах зорилгоор хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж, ажил олгогчдын хариуцлагыг нэмэгдүүлэх хөтөлбөр арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай.
- МБСБ-ын төгсөгчдийн ажлын байранд зуучлагдах хэлбэр, ажил хайх оролдлогын эхний алхмуудын нэгэнд амьдарч буй аймаг, дүүргийн ХХҮГ болон хөдөлмөрийн биржид хандах, бүртгүүлэх дадлыг бий болгох, сурталчлах хэрэгтэй юм.
- Цаашид хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, зээлийн хүүг бууруулах, залуучуудыг төсөл, хөтөлбөрийн санхүүжилтэд хамруулах боломжийг өргөжүүлэх, хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай.

